



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2023 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 25-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2023 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр, Мягмар гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>1</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>2-31</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>32-67</i>
<hr/>	
<i>1. Төмөр замын тээврийн тухай /Шинэчилсэн найруулга/ хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.01.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	<i>33-36</i>
<i>2. Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.11.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	<i>36-67</i>

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
Эдийн засгийн байнгын хорооны 04 дүгээр сарын 25-ны өдөр
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Эдийн засгийн байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 18 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 55.5 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 18 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Баттөмөр, Т.Доржханд, М.Оюунчимэг, Ч.Ундрэм,
Ч.Хүрэлбаатар, О.Цогтгэрэл;
Чөлөөтэй: Ж.Ганбаатар, Ц.Даваасүрэн.

Нэг.Төмөр замын тээврийн тухай /Шинэчилсэн найруулга/ хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.01.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Зам, тээврийн хөгжлийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга М.Энхболд, мөн газрын Усан замын тээврийн хэлтсийн дарга Д.Жавхлан, Төмөр замын тээврийн хэлтсийн дарга Х.Итгэлт, мөн хэлтсийн ахлах шинжээч Л.Булганхүү, шинжээч Ц.Наранчимэг, мөн яамны Хуулийн хэлтсийн дарга С.Мяндасмаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ё.Энхсайхан, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ танилцуулав.

Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Хуулийн төсөлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Төмөр замын тээврийн тухай /Шинэчилсэн найруулга/ хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол

Ц.Цэрэнпунцаг: 1.Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ, А.Адъяасүрэн, Э.Бат-Амгалан, Б.Баттөмөр, Б.Жавхлан, М.Оюунчимэг, С.Чинзориг цаашид /“Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.7 дахь заалт буюу “нийтийн зориулалттай төмөр зам”, 4.1.8 дахь заалт буюу “тусгай зориулалтын төмөр зам” гэсэн нэр томъёог доор дурдсанаар өөрчлөн найруулж, төсөлд тусгагдсан эдгээр нэр томъёог тохиолдол бүрд нийцүүлэн өөрчлөх:

“4.1.7.“нийтийн төмөр зам” гэж нийтэд тээврийн үйлчилгээ үзүүлэх зориулалт бүхий төмөр замын суурь бүтцийг;

4.1.8.“үйлдвэрлэлийн зориулалттай төмөр зам” гэж аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд зориулагдсан төмөр замын суурь бүтцийг;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 2
Бүгд: 10
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийн 7.1.5 дахь заалтын “30 дугаар зүйлийн 30.1-т заасан хилийн бүсэд” гэснийг “26.1-д заасан хилийн зурваст” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 2
Бүгд: 10
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 24 дүгээр зүйлийн 24.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“24.3.Төмөр замын суурь бүтцийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр барих тохиолдолд суурь бүтцийг төрийн өмчлөлд шилжүүлэх хугацаа, нөхцөлийг түншлэлийн гэрээнд тусгах бөгөөд түншлэлийн хугацаанд суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч нь тээвэрлэгчийн үйл ажиллагаа эрхэлж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 2
Бүгд: 10
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Найруулгын санал:

Төслийн 11.1.10 дахь заалт болон 31.3 дахь хэсгийн “зориулалттай” гэсний өмнө “тээврийн” гэж, 25.1.6 дахь заалтын “хангах” гэсний өмнө “мэдээллээр” гэж тус тус нэмэн, 4.1.3 дахь заалтын “үйлчилгээ үзүүлэх” гэснийг “үйл ажиллагаа эрхлэх” гэж, 4.1.22 дахь заалтын “сэлгээний ажлыг” гэснийг, “сэлгээний хөдөлгөөнийг” гэж, 4.1.23 дахь заалтын “нэг түвшинд” гэснийг “ижил түвшинд” гэж, 9.1.3 дахь заалтын “олгох” гэснийг “ашиглуулах” гэж, 20.3 дахь хэсгийн “сүлжээг хөгжүүлэхэд” гэснийг “сүлжээний төлөвлөлтөд” гэж, 26.4 дэх хэсгийн “аливаа этгээдэд” гэснийг “бусдад” гэж, 36.4.5 дахь заалтын “ачаа” гэснийг “, дутсан ачаа” гэж тус тус өөрчлөн, 32.7 дахь хэсгийн “өмчлөгч,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 2
Бүгд: 10
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Дээрх саналуудтай нийцүүлэн Байнгын хорооны 2023 оны 03 дугаар сарын 28, 04 дүгээр сарын 04-ний өдрийн хуралдаанаар дэмжигдсэн саналын томъёоллын 24.2-т тусгагдсан “нийтийн зориулалттай төмөр замд” гэсэн нэр томъёог “нийтийн төмөр замд” гэж, 32.1-д тусгагдсан “сэлгээний ажил” гэснийг “сэлгээний хөдөлгөөн” гэж, 9.1.5-д тусгагдсан “эзэмшүүлэх” гэснийг “эзэмших, ашиглах” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 2
Бүгд: 10
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Гурав.Төмөр замын тээврийн тухай /Шинэчилсэн найруулга/ хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол

Ц.Цэрэнпунцаг: 1.Ажлын хэсгийн гаргасан, Байнгын хорооны 2023 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаар төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед дэмжигдсэн “1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 14.10 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн “эзэмшигч нь” гэсний өмнө “өмчлөгч,” гэж нэмэх” гэсэн саналыг хүчингүй болгох гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 2
Бүгд: 10
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 14.10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “мянган” гэсний өмнө “нэг” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 2
Бүгд: 10
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дуусав.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Монгол Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 46 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.11.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Байгаль

орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Цогтгэрэл, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэмүүлэн, Хууль зүй, дотоод хэргийн яамны ахлах шинжээч Н.Жамъянхүү, “Монголын эрх зүйн судалгаа хөгжлийн төв” Төрийн бус байгууллагын хуульч, судлаач Р.Лхагвабаяр нар байлцав.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг танилцуулав.

Ажлын хэсгийн танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Ганибал, Т.Энхтүвшин нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлан санал хураах төхөөрөмжид саатал гарсан учир санал хураалтыг гар өргөж явуулья гэсэн горимын санал гаргав.

Ц.Цэрэнпунцаг: Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлангийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	7
Татгалзсан:	3
Бүгд:	10

70.0 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т заасны дагуу санал хураалтыг гар өргөж явуулахаар тогтов.

Хуулийн төсөлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол

Ц.Цэрэнпунцаг: 1. Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, Ш.Адъяа, Х.Булгантуяа, Т.Доржханд, М.Оюунчимэг цаашид /“Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “аялал жуулчлалын үйлдвэрлэлээр эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, дэмжихтэй холбогдсон болон” гэснийг “аялал жуулчлалыг хөгжүүлэх, нийгэм, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх,” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	9
Татгалзсан:	1
Бүгд:	10

90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “энэ хууль тогтоомжоос” гэснийг “Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 1
Бүгд: 10
90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.1.Энэ хуулиар Монгол Улсын нутаг дэвсгэр дэх аялал жуулчлалын үйл ажиллагааг зохицуулна.

3.2.Тусгай хамгаалалтай газар нутаг дахь аялал жуулчлалын үйл ажиллагааг энэ хууль болон Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулиар зохицуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 1
Бүгд: 10
90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтын “нэг хоногоос” гэснийг, 4.1.4 дэх заалтын “2, түүнээс дээш” гэснийг, 4.1.6 дахь заалтын “жигжиглэн, эсхүл хоёр, түүнээс дээш бүтээгдэхүүн, үйлчилгээг багцлан,” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 1
Бүгд: 10
90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.11 дэх заалтын “аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг эрхлэхэд шаардагдах газрын гадаргуу дээрх” гэснийг “үйл ажиллагаанд ашиглах” гэж өөрчилж, “археологи” гэсний өмнө “палеонтологи” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 1
Бүгд: 10
90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.10 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.10.“аялал жуулчлалын дэд бүтэц” гэж нисэх буудал, зам, тээвэр, эрчим хүч, ус хангамж, ариун цэврийн байгууламж, улсын, олон улсын болон орон нутгийн чанартай авто зам дагуух үйлчилгээний байгууламж, тэмдэг тэмдэглэгээ, харилцаа, холбоо,

мэдээлэл технологийн цахим дэд бүтцийг;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 1
Бүгд: 10
90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.2.“жуулчин” гэж энэ хуулийн 4.1.1-д заасан аялал жуулчлалын үйл ажиллагаанд хамрагдаж байгаа хүнийг;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 1
Бүгд: 10
90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.5.“аялал жуулчлалын үйлчилгээний байгууллага” гэж байр сууц, тээвэр, хоол үйлдвэрлэл, үзмэр, үзвэр үйлчилгээ, жуулчны мэдээллийн төв зэрэг жуулчинд зориулсан үйлчилгээ эрхэлж байгаа хуулийн этгээдийг;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 1
Бүгд: 10
90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.7 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.7.“аяллын агент” гэж тур оператор болон аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагын бүтээгдэхүүн, үйлчилгээг зуучлан борлуулж байгаа хуулийн этгээдийг;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 1
Бүгд: 10
90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.9 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.9.“тусгай сонирхлын аялал жуулчлал” гэж тусгай мэргэжлийн ур чадвар, техник хэрэгсэл шаардсан аялал жуулчлалыг;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 1
Бүгд: 10
90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 1
Бүгд: 10
90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“4.1.12.“нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал” гэж тухайн орон нутгийн иргэд, нөхөрлөл жуулчинд энэ хуулийн 11.1-д заасан бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлэхийг;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 1
Бүгд: 10
90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“4.1.13.“отоглох цэг” гэж аялал жуулчлалын эрэлт, байгаль орчны даацад нийцүүлэн хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэхэд зориулагдсан, өөрийн стандарт бүхий, жуулчинд зориулсан түр байрлах үйлчилгээний цогц орчныг;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 1
Бүгд: 10
90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн “бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх, тэдгээрийг хэрэглэгчдэд хүргэх үйлдвэрлэл, үйл ажиллагаа нь аялал жуулчлалын” гэснийг “үйлдвэрлэл нь” гэж, мөн зүйлийн 5.2.3 дахь заалтын “бүтээгдэхүүн” гэснийг “бүтээгдэхүүн, үйлчилгээ” гэж, 5.3.3 дахь заалтын “урлаг, үзвэр үйлчилгээ” гэснийг “үзмэр болон урлаг” гэж, мөн зүйлийн 5.4 дэх хэсгийн “энэ хуулийн 5.2, 5.3-т заасан аялал жуулчлалын байгууллагын гадаадын жуулчинд үзүүлсэн үйлчилгээ” гэснийг-“аялал жуулчлалын байгууллагын гадаадын жуулчинд үзүүлсэн энэ хуулийн 5.2, 5.3-т заасан үйлчилгээ” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 1

Бүгд: 10
90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5.3.4 дэх заалтын “худалдаа” гэсний өмнө “жуулчинд зориулсан гар урлалын болон бусад” гэж нэмж, төслийн 5.3.5 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 1
Бүгд: 10
90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн 6.3, 6.8 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 1
Бүгд: 10
90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсгийн “6.2-т заасан ангилалд тусгагдаагүй байгууллага тусгай сонирхлын болон бусад төрлийн эрсдэл бүхий аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэх” гэснийг “6.2.1, 6.2.2-т зааснаас бусад байгууллага эрсдэл бүхий аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлэх” гэж, 6.9 дэх хэсгийн “соёлын биет өв буюу түүх, соёлын үл хөдлөх болон хөдлөх дурсгалт зүйлийн” гэснийг “соёлын биет өвийн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 1
Бүгд: 10
90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.1.1.аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг төлөвлөн бүрдүүлж, шууд, эсхүл аяллын агентаар дамжуулан худалдан борлуулах, аялал зохион байгуулах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 1
Бүгд: 10
90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийн 7.2.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.2.2.аялал жуулчлалын мэдээллийн санд үйл ажиллагааныхаа статистик мэдээллийг маягтын дагуу тогтоосон хугацаанд ирүүлэх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 1
Бүгд: 10
90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийн 7.2.7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.2.7.бүтээгдэхүүн, үйлчилгээ болон байгууллагынхаа үйл ажиллагааны талаар мэдээлэл авах боломжийг цахим орчинд бүрдүүлсэн байх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 1
Бүгд: 10
90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

21.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийн 7.2.1 дэх заалтын “түүх,” гэснийг “хууль тогтоомж, түүх, соёл,” гэж, 7.2.6 дахь заалтын “хэлбэрийг хөгжүүлэх” гэснийг “бүтээгдэхүүн, үйлчилгээг үзүүлэх” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 1
Бүгд: 10
90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

22.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийн 7.1.5 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 1
Бүгд: 10
90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

23.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтын “бүтээгдэхүүнийг” гэснийг “болон аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагын бүтээгдэхүүн, үйлчилгээг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 1
Бүгд: 10
90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

24.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.1.3 дахь заалт, мөн зүйлийн 8.2 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 1
Бүгд: 10
90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

25.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, мөн зүйлийн 9.2.2, 9.2.4, 9.2.5 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 1
Бүгд: 10
90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

26.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийн “Хөтөч” гэсний өмнө “Аялал жуулчлалын мэргэжилтэй, эсхүл” гэж, мөн зүйлийн 10.2.2 дахь заалтын “үндэсний” гэсний өмнө “хууль тогтоомж,” гэж, 10.3 дахь хэсгийн “журмыг” гэсний өмнө, мөн 10.4 дэх хэсгийн “чиг үүргийг” гэсний өмнө “болон мэргэжлийн ур чадварын зэрэглэл тогтоох” гэж тус тус нэмж, мөн 10.4 дэх заалтын “журмын дагуу” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 1
Бүгд: 10
90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

27.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлийн 10.5 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 1
Бүгд: 10
90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

28.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 11 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“11 дүгээр зүйл.Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал

11.1.Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалд жуулчинд зориулсан дараах бүтээгдэхүүн, үйлчилгээ хамаарна:

11.1.1.нүүдэлчдийн соёл, ахуй, зан заншлыг танилцуулан сурталчлах;
11.1.2.зочны гэрээр үйлчлэх;
11.1.3.ердийн хөсгөөр үйлчлэх;
11.1.4.энэ хуулийн 5.3-т заасан аялал жуулчлалын дагалдах бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлэх.

11.2.Төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал хөгжүүлэхийг дэмжиж ажиллана.

11.3.Улсын болон орон нутгийн аялал жуулчлалын бүсэд нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал эрхлэхэд энэ хуулийн 19.16-д заасан бүсийн төлөвлөлтийг баримтална.

11.4.Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг эрхлэгч нь эрх бүхий байгууллагаас баталсан техникийн зохицуулалт, стандартыг үйл ажиллагаандаа мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 1
Бүгд: 10
90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

29.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 12 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“12 дугаар зүйл.Тур операторын бүртгэл

12.1.Энэ хуулийн 6.5-д заасны дагуу тур операторыг дараах ангиллаар бүртгэнэ:

12.1.1.Монгол Улсаас бусад улс руу хийх аялал жуулчлалын үйлчилгээ;
12.1.2.бусад улсаас Монгол Улс руу хийх аялал жуулчлалын үйлчилгээ;
12.1.3.энэ хуулийн 12.1.1 болон 12.1.2-т заасан аялал жуулчлалын үйлчилгээг хамтад нь эрхлэх олон улсын аялал жуулчлалын үйлчилгээ.

12.1.4.дотоодын аялал жуулчлалын үйлчилгээ.

12.2.Тур оператороор бүртгүүлэхдээ дараах мэдээллийг ирүүлнэ:

12.2.1.аялал жуулчлалын мэргэжлийн ажилтны мэдээлэл;
12.2.2.бүтээгдэхүүн, үйлчилгээний талаарх мэдээлэл;
12.2.3.цахим төлбөрийн баримтын систем, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд холбогдсон талаарх мэдээлэл;

12.2.4.хариуцлагын даатгалд хамрагдсан талаарх мэдээлэл.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 1
Бүгд: 10
90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

30.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсгийн “нутаг дэвсгэрт” гэсний дараа “энэ хуулийн 13.1-д заасан гадаадын иргэн” гэж нэмж, 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсгийн “12.2.2-т заасан үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөлтэй” гэснийг “12.1.2, 12.1.3-т заасан ангиллаар бүртгүүлсэн” гэж, мөн зүйлийн 13.6 дахь хэсгийн “энэ зүйлд заасны дагуу хил орчмын аялал жуулчлалын үйлчилгээ авч буй гадаадын жуулчны мэдээллийг” гэснийг “хил орчмын аялал жуулчлалын үйлчилгээ авч байгаа жуулчны тоон мэдээллийг” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 1
Бүгд: 10
90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

31.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 15 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“15 дугаар зүйл.Даатгал

15.1.Тур оператор, аяллын агент нь үйл ажиллагаандаа алдаа гаргасны улмаас үйлчлүүлэгчид учруулсан хохирлыг нөхөн төлөх зорилгоор хариуцлагын даатгалд заавал даатгуулна.

15.2.Өндөр уулын авиралт, спорт агнуур, олзворын ан, усны гүнд шумбах, авто спорт, нисдэг тэрэгний аялал зэрэг хүний амь нас, эрүүл мэндэд өндөр эрсдэл бүхий аялалд оролцох жуулчин, жуулчны хөтөч-тайлбарлагч, мэргэшсэн сургагч багш, зааварлагч нь гэнэтийн ослын даатгалд заавал даатгуулсан байна.

15.3.Энэ хуулийн 15.2-т заасан жуулчныг уг даатгалд хамруулах үйл ажиллагааг аялал жуулчлалын байгууллага хариуцан зохион байгуулна.

15.4.Энэ хуулийн 15.1, 15.2-т заасан даатгалын эрсдэл, нөхцөл, үнэлгээ, хураамжийн хэмжээг тогтоох, хяналт тавих журмыг аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Санхүүгийн зохицуулах хороотой хамтран батална гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 1

Бүгд: 10

90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

32.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийн “аялж байгаа жуулчинд шаардагдах аюулгүй байдлыг аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага,” гэснийг “жуулчны аюулгүй байдлыг” гэж, мөн зүйлийн 16.5 дахь хэсгийн “тур оператор, аяллын агент, аялал жуулчлалын үйлчилгээний байгууллага, жуулчдад мэдэгдэх” гэснийг “аялал жуулчлалын байгууллага, жуулчинд мэдээлэх бөгөөд өөрийн албан ёсны цахим хуудсанд тухай бүр байршуулах” гэж өөрчилж, 16 дугаар зүйлийн 16.4, 16.7 дахь хэсгийн “бүхий л” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 1

Бүгд: 10

90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

33.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 16 дугаар зүйлийн 16.6, 16.8 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 1

Бүгд: 10

90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

34.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 17 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 1
Бүгд: 10
90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

35.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 18 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 1
Бүгд: 10
90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

36.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 19 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“19 дүгээр зүйл. Аялал жуулчлалын бүс

19.1. Монгол Улс тодорхой газар нутгийг тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх, гадаадын болон дотоодын хөрөнгө оруулалтыг татах, аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг төрөлжүүлэн хөгжүүлэх зорилгоор орон зайн зохистой төлөвлөлтийг бий болгосон аялал жуулчлалын бүстэй байна.

19.2. Аялал жуулчлалын бүсийг дараах байдлаар ангилна:

- 19.2.1. улсын аялал жуулчлалын бүс;
- 19.2.2. орон нутгийн аялал жуулчлалын бүс.

19.3. Улсын аялал жуулчлалын бүсийг тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх, аялал жуулчлалын салбарт хөрөнгө оруулалтыг дэмжих, байгаль, түүх, соёлын өв, аялал жуулчлалын нөөцийг хамгаалах зорилгод нийцүүлэн, улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд үндэслэн Засгийн газраас тогтоож, хил заагийг батална.

19.4. Улсын аялал жуулчлалын бүсийн хилийн заагийг тогтооход газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон аялал жуулчлалыг хөгжүүлэх Үндэсний хорооны саналыг авна.

19.5. Улсын аялал жуулчлалын бүсэд аялал жуулчлалын үйл ажиллагаа, газар ашиглалтад холбогдох техникийн зохицуулалт, стандартыг мөрдөх бөгөөд түүнд нийцсэн менежментийн төлөвлөгөөтэй байна.

19.6. Энэ хуулийн 19.5-д заасан менежментийн төлөвлөгөө, бүсийн аялал жуулчлалын маршрутыг аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

19.7. Орон нутгийн аялал жуулчлалын бүсийн хилийн заагийг аймаг, нийслэлийн аялал жуулчлалын асуудал хариуцсан нэгж аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нийцүүлэн боловсруулна.

19.8.Энэ хуулийн 19.7-д заасан хилийн заагийг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал баталж, газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системд болон энэ хуулийн 28.1-д заасан мэдээллийн санд хүргүүлнэ.

19.9.Орон нутгийн аялал жуулчлалын бүс нь менежментийн төлөвлөгөөтэй байна. Орон нутгийн аялал жуулчлалын бүсийн газар зохион байгуулалтын асуудлыг аймаг, нийслэл, сум, дүүргийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлнэ.

19.10.Улсын аялал жуулчлалын бүсэд хамаарах аймаг, нийслэл, сум, дүүргийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд аялал жуулчлалын газрын ашиглалт, хамгаалалтын асуудлыг тусгаж, хэрэгжүүлэхдээ энэ хуулийн 19.5-д заасан техникийн зохицуулалт, стандартыг мөрдөнө.

19.11.Энэ хуулийн 19.9-д заасан орон нутгийн аялал жуулчлалын бүсийн менежментийн төлөвлөгөөг аймаг, нийслэлийн аялал жуулчлалын асуудал хариуцсан нэгж боловсруулж, аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална.

19.12.Улсын аялал жуулчлалын бүсийн менежментийг аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, орон нутгийн аялал жуулчлалын бүсийн менежментийг аймаг, нийслэлийн Засаг дарга хариуцан зохион байгуулна.

19.13.Аялал жуулчлалын бүсийн менежментийг бүхэлд нь, эсхүл тодорхой хэсгийг гэрээний үндсэн дээр хуулийн этгээдээр гүйцэтгүүлж болно.

19.14.Орон нутгийн аялал жуулчлалын бүсийн газар нутгийн хилийн заагийг тогтоохдоо улсын аялал жуулчлалын бүсийн газар нутгийн хилийн заагтай давхцуулж тогтоохыг хориглоно.

19.15.Улсын аялал жуулчлалын бүстэй орон нутгийн аялал жуулчлалын бүс давхацсан тохиолдолд давхацсан хэсгийг холбогдох иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хүчингүй болгоно.

19.16.Улсын болон орон нутгийн аялал жуулчлалын бүсэд үйл ажиллагаа эрхлэх аялал жуулчлалын үйлчилгээний байгууллага, нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал эрхлэгч хоорондын орон зайн төлөвлөлтөд холбогдох техникийн зохицуулалт, стандартыг заавал дагаж мөрдөнө гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 1
Бүгд: 10
90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

37.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 20 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

20 дугаар зүйл.Отоглох цэг

20.1.Улсын аялал жуулчлалын бүс болон улсын тусгай хамгаалалттай газар нутагт аялал жуулчлалын эрэлт, байгаль орчны даацыг үндэслэн байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага отоглох цэг байгуулах байршлыг тогтооно.

20.2.Энэ хуулийн 20.1-д заасан улсын тусгай хамгаалалттай газар нутагт отоглох цэгийг улсын төсвийн, тухайн тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны болон олон улсын төслийн хөрөнгө оруулалтаар байгуулна.

20.3.Энэ хуулийн 20.1-д заасан улсын тусгай хамгаалалттай газарт отоглох цэгийн менежментийг тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа хэрэгжүүлэх бөгөөд менежментийг гэрээний үндсэн дээр хуулийн этгээд, орон нутгийн иргэнээр гүйцэтгүүлж болно.

20.4.Энэ хуулийн 20.1-д заасан улсын аялал жуулчлалын бүс нь улсын тусгай хамгаалалттай газартай давхцаагүй тохиолдолд тухайн аялал жуулчлалын бүс дэх отоглох цэгийн менежментийг гэрээний үндсэн дээр хуулийн этгээд, орон нутгийн иргэнээр гүйцэтгүүлж болно.

20.5.Энэ хуулийн 20.4-т заасан отоглох цэгийн менежментийг гэрээний үндсэн дээр гүйцэтгэх этгээдийг аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага сонгон шалгаруулна.

20.6.Энэ хуулийн 20.1-д заасан улсын тусгай хамгаалалттай газарт отоглох цэгийн үйлчилгээний хураамж авах, зарцуулахтай холбогдсон харилцааг Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулиар зохицуулна.

20.7.Отоглох цэг нь байнгын, эсхүл түр байж болох бөгөөд стандартын шаардлага хангасан байна.

20.8.Отоглох цэгт олон нийтийн аюулгүй байдлыг хангах харилцааг Цагдаагийн албаны тухай хуулиар зохицуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 1
Бүгд: 10
90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

38.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн Гуравдугаар бүлгийн гарчгийг “АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БҮС” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 1
Бүгд: 10
90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

39.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн Дөрөвдүгээр бүлгийн гарчгийн “БАЙГУУЛЛАГА, АШГИЙН ТӨЛӨӨ БУС” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 1
Бүгд: 10
90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

40.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 21 дүгээр зүйлийн 21.1.5 дахь заалтын “хуулийн” гэсний дараа “6.6, 21.5,” гэж, 21.2.1 дэх заалтын “боловсруулах” гэсний дараа “болон хэрэгжүүлэх асуудлаар Ерөнхий сайдад зөвлөгөө өгөх, санал гаргах” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 1
Бүгд: 10
90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

41.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 21 дүгээр зүйлийн 21.1.6 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“21.1.6.аялал жуулчлалын дэд бүтцийг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөг батлах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 1
Бүгд: 10
90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

42.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 21 дүгээр зүйлийн 21.2.3 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 1
Бүгд: 10
90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

43.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 21 дүгээр зүйлийн 21.3 дахь хэсэг, 21.4 дэх хэсгийг тус тус доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“21.3.Үндэсний хороог Ерөнхий сайд тэргүүлэх бөгөөд байгаль орчин, аялал жуулчлал, төсөв, санхүү, эдийн засаг, тээвэр, эрчим хүч, гадаад харилцаа, хууль зүй, соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас санал болгосон тус бүр нэг, энэ хуулийн 27.1-д заасан нийтийн эрх зүйн хуулийн этгээдээс санал болгосон таван гишүүнээс бүрдэнэ.

21.4.Үндэсний хороо орон тооны бус байх бөгөөд гишүүдийг Ерөнхий сайд томилж, чөлөөлнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 1
Бүгд: 10
90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

44.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 21 дүгээр зүйлийн 21.2-21.5 дахь хэсгийг 22 дугаар зүйл болгон зүйлийн нэрийг “Аялал жуулчлалыг хөгжүүлэх Үндэсний хорооны бүрэн эрх” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 1
Бүгд: 10
90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

45.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“22.1.13.аялал жуулчлалын талаар төрөөс баримтлах бодлого, хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулж, биелэлтэд хяналт тавих.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 1
Бүгд: 10
90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

46.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 22 дугаар зүйлийн 22.1.1 дэх заалтын “6.6, 10.3, 11.3-г” гэснийг “10.3, 15.4-г” гэж, 22.1.5 дахь заалтын “жуулчны үйлчилгээний байгууллагын” гэснийг “аялал жуулчлалын үйлчилгээний байгууллага, нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал эрхлэгчийн” гэж, 22.1.7 дахь заалтын “үйлдвэрлэл, үйлчилгээ” гэснийг “үйлдвэрлэлийг хөгжүүлэх” гэж, 22 дугаар зүйлийн 22.1.11 дэх заалтын “бий болгоход дэмжлэг үзүүлэх” гэснийг “хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 1
Бүгд: 10
90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

47.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 22 дугаар зүйлийн 22.1.7 дахь заалт, 22.1.9 дэх заалтын “боловсруулах” гэсний дараа “, хэрэгжүүлэх” гэж, 22.1.4 дэх заалтын “аялал жуулчлалын” гэсний дараа “хүний нөөцийг бэлтгэх, мэргэжлийн удирдлагаар хангах” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 1
Бүгд: 10
90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

48.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 1
Бүгд: 10
90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

49.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 24 дүгээр зүйлийн 24.1.4 дэх заалтын “батлагдсан хөтөлбөрийн дагуу аялал жуулчлалын төлөвлөгөө боловсруулж” гэснийг, 24.1.5 дахь заалтын “эрх хэмжээнийхээ хүрээнд” гэснийг, 24.1.7 дахь заалтын “наадам,

бусад” гэснийг тус тус хасаж, 24 дүгээр зүйлийн 24.1.7 дахь заалтын “тухайн жилийн” гэснийг “өмнөх оны” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 1
Бүгд: 10
90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

50.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 24 дүгээр зүйлийн 24.1.12 дахь заалтын “харьяалах” гэсний өмнө “шаардлагатай тохиолдолд” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 1
Бүгд: 10
90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

51.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 24 дүгээр зүйлийн 24.1.8, 24.1.11 дэх заалт, мөн зүйлийн 24.2 дахь хэсэг болон “Тайлбар” хэсгийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 1
Бүгд: 10
90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

52.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“24.1.15.харьяалах нутаг дэвсгэртээ улсын болон олон улсын чанартай авто замын дагуу аялал жуулчлалын үйлчилгээ эрхлэгч иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, жуулчинд үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд хамтран ажиллах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 1
Бүгд: 10
90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

53.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“24.1.16.аялал жуулчлалыг хөгжүүлэх хэрэгцээ, шаардлагыг харгалзан аймаг, нийслэлд аялал жуулчлалын асуудал хариуцсан нэгж, эсхүл ажилтан ажиллуулах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 1
Бүгд: 10
90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

54.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 25 дугаар зүйлийн 25.1.3, 25.1.4 дэх заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 1
Бүгд: 10
90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

55.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 26 дугаар зүйлийн 26.1.8 дахь заалт, мөн зүйлийн 26.2 дахь хэсгийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 1
Бүгд: 10
90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

56.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 26 дугаар зүйлийн 26.1.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“26.1.3.харьяалах нутаг дэсвгэртээ байгуулах жуулчны үйлчилгээний байгууллагад газар эзэмших зөвшөөрлийг аялал жуулчлалын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын тогтоосон нөөц, даац, тоо, байршлыг баримтлан хууль тогтоомжийн дагуу олгож гэрээ байгуулах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 1
Бүгд: 10
90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

57.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 26 дугаар зүйлийн 26.1.4 дэх заалтын “аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлэгч иргэний үйл ажиллагааг хөгжүүлэхэд” гэснийг “нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалын үйл ажиллагаанд” гэж, 26.1.7 дахь заалтын “отоглох цэгийн байршил, аяллын маршрутыг тогтоох,” гэснийг “аяллын маршрутын дагуу” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 1
Бүгд: 10
90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

58.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 27 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, Тавдугаар бүлэг болгон өөрчлөх.

“ТАВДУГААР БҮЛЭГ.АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН МЭРГЭЖЛИЙН ХОЛБОО

27 дугаар зүйл.Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо

27.1.Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо нь тур оператор, аяллын агент, аялал жуулчлалын үйлчилгээний байгууллага, жуулчны хөтөч-тайлбарлагч, нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал эрхлэгчийн нэгдэл бүхий, аялал жуулчлалын үйл ажиллагаанд

оролцогчдыг сургалт, зөвлөгөө, мэдээлэл, мэргэжлийн арга зүйгээр хангах, аялал жуулчлалын байгууллагын ажилтны баримтлах мэргэжлийн ёс зүйн дүрмийг батлах, боловсронгуй болгох үндсэн чиг үүрэг бүхий ашгийн төлөө бус нийтийн эрх зүйн хуулийн этгээд /цаашид “холбоо” гэх/ байна.

27.2.Холбооны зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбогдсон энэ хуулиар зохицуулаагүй харилцааг холбооны дүрмээр зохицуулна.

27.3.Холбоо нь аялал жуулчлалын салбарын мэргэжилтнүүдийн мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр төрийн, ашгийн төлөө бус хуулийн этгээд болон олон улсын байгууллагатай хамтран ажиллаж болно.

27.4.Холбоо нь тухайн жилийн үйл ажиллагааны тайлангаа дараа оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн дотор аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, аудитлагдсан санхүүгийн тайлангаа харилцагч санхүүгийн байгууллагад, татварын тайлангаа харьяалах татварын албанд хуульд заасан хугацаанд хүргүүлж, олон нийтэд нээлттэй мэдээлнэ гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 1

Бүгд: 10

90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

59.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн Тавдугаар бүлэгт доор дурдсан агуулгатай 28 дугаар зүйл нэмэх:

“28 дугаар зүйл.Холбооны их хурал

28.1.Холбооны эрх барих дээд байгууллага нь Аялал жуулчлалын мэргэжлийн холбооны их хурал /цаашид “их хурал” гэх/ байна.

28.2.Их хурал нь ээлжит болон ээлжит бус хэлбэртэй байх бөгөөд ээлжит хурлыг жилд нэг удаа хуралдуулна.

28.3.Их хурлын төлөөлөгчдийн олонх оролцсоноор хурал хүчин төгөлдөр болно.

28.4.Их хуралд оролцох төлөөлөгчдийг сонгох журмыг холбооны дүрмээр тогтооно.

28.5.Их хурлын төлөөлөгчид нь холбооны гишүүнчлэлтэй аялал жуулчлалын байгууллагын төлөөллөөс бүрдэнэ.

28.3.Их хурал дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

28.3.1.холбооны дүрмийг батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах;

28.3.2.аялал жуулчлалын салбарын ажилтны мэргэжлийн ёс зүйн дүрмийг батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах;

28.3.3.холбооны Удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох, чөлөөлөх.

28.3.4.холбооны Удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны тайланг хэлэлцэх, санал, зөвлөмж өгөх;

28.3.4.хууль болон холбооны дүрмээр тогтоосон бусад асуудал.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 1
Бүгд: 10
90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

60.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн Тавдугаар бүлэгт доор дурдсан агуулгатай 29 дүгээр зүйл нэмэх:

“29 дүгээр зүйл.Холбооны Удирдах зөвлөл

29.1.Холбооны Удирдах зөвлөл /цаашид “Удирдах зөвлөл” гэх/ нь Их хурлын чөлөөт цагт холбооны үйл ажиллагааг зохион байгуулах чиг үүрэг бүхий хамтын удирдлагын байгууллага байна.

29.2.Удирдах зөвлөл нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

29.2.1.холбооны гүйцэтгэх удирдлагыг томилох, чөлөөлөх;
29.2.2.холбооны дүрэм, журмын хэрэгжилт, жилийн ажлын төлөвлөгөө, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавих;

29.2.3.холбооны их хурлыг зарлан хуралдуулах;
29.2.4.холбооны жилийн төсөв, ажлын төлөвлөгөөг батлах, үйл ажиллагааны тайланг хэлэлцэх;

29.2.5.хууль болон холбооны дүрэмд заасан бусад бүрэн эрх.

29.3.Удирдах зөвлөл 15 гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд тур оператораас 5, аяллын агент, зочид буудал, жуулчны бааз, агаарын тээврийн үйлчилгээ үзүүлэгч компани болон аялал жуулчлалын үйлчилгээний бусад байгууллагаас тус бүр 2 төлөөллөөс бүрдэнэ.

29.4.Удирдах зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа 3 жил байх бөгөөд улируулан сонгохгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 1
Бүгд: 10
90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

61.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн Тавдугаар бүлэгт доор дурдсан агуулгатай 30 дугаар зүйл нэмэх:

“30 дугаар зүйл.Холбооны гүйцэтгэх удирдлага

30.1.Холбооны гүйцэтгэх удирдлагын бүрэн эрхийн хугацаа гурван жил байх бөгөөд улируулан сонгохгүй.

30.2.Холбооны гүйцэтгэх удирдлага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

30.2.1.холбоог гадаад, дотоод харилцаанд төлөөлөх;
30.2.2.холбооны үйл ажиллагааг удирдан явуулах;
30.2.3.холбооны төсөв, төлөвлөгөөг боловсруулах, батлуулах;
30.2.4.санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг хуульд заасан журмын дагуу гаргах, эрх бүхий байгууллагаар хэлэлцүүлэх, холбогдох байгууллагад хүргүүлэх;

30.2.5.Удирдах зөвлөлөөс олгосон бүрэн эрхийн хүрээнд холбоог төлөөлөн гэрээ, хэлцэл хийх;

30.2.6.хууль болон холбооны дүрэмд заасан бусад бүрэн эрх.

30.3.Холбооны гүйцэтгэх удирдлага нь Аялал жуулчлалыг хөгжүүлэх Үндэсний хорооны бүрэлдэхүүнд ажиллана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 1

Бүгд: 10

90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

62.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 28 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, Зургаадугаар бүлэгт тусгах:

“28 дугаар зүйл.Аялал жуулчлалын мэдээллийн сан

28.1.Аялал жуулчлалын салбарын судалгаа, шинжилгээ, статистик мэдээллийн нэгдсэн сан /цаашид “Аялал жуулчлалын мэдээллийн сан” гэх/-г аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага цахим хэлбэрээр бүрдүүлнэ.

28.2.Аялал жуулчлалын мэдээллийн сан нь дараах мэдээллээс бүрдэнэ:

28.2.1.хууль тогтоомжийн болон салбарын хүний нөөцийн мэдээлэл;

28.2.2.дотоодын болон олон улсын жуулчны тоон мэдээлэл;

28.2.3.аялал жуулчлалын байгууллагын бүртгэл, мэдээлэл;

28.2.4.улсын, орон нутгийн, хил орчмын аялал жуулчлалын бүс, маршрутын мэдээлэл;

28.2.5.олон улсын, улсын болон орон нутгийн чанартай авто зам дагуух үйлчилгээний байгууламжийн мэдээлэл;

28.2.6.энэ хуулийн 20 дугаар зүйлд заасан отоглох цэгийн мэдээлэл;

28.2.7.энэ хуулийн 16.5-д заасан жуулчдад учирч болзошгүй аюул, халдварт өвчин, тахал болон зорчиход аюултай газар, байршлын талаарх мэдээлэл.

28.3.Аялал жуулчлалын мэдээллийн сан нь нийтэд нээлттэй байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 1

Бүгд: 10

90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

63.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн Тавдугаар бүлгийн гарчгийг “Зургаадугаар бүлэг.Бусад зүйл” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 1
Бүгд: 10
90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

64.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 29 дүгээр зүйлийн 29.4, 29.5 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 1
Бүгд: 10
90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

65.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 29.2-29.6 дахь заалтыг 30 дугаар зүйл болгон өөрчилж, зүйлийн гарчгийг “30 дугаар зүйл.Аялал жуулчлалын үйл ажиллагаанд тавих төрийн хяналт” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 1
Бүгд: 10
90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

66.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 30 дугаар зүйлийн 30.1.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

“30.1.1.аялал жуулчлалын хууль тогтоомжийг зөрчсөн тухай өргөдөл, гомдлыг эрх бүхий байгууллагад гаргаж, шийдвэрлүүлэх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 1
Бүгд: 10
90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

67.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 32 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“32 дугаар зүйл.Шилжилтийн үеийн зохицуулалт

32.1.Энэ хуулийн 27 дугаар зүйлд заасан нийтийн эрх зүйн хуулийн этгээдийг үүсгэн байгуулах хурлыг аялал жуулчлалын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан журмын дагуу аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хууль батлагдсан өдрөөс хойш 90 хоногийн дотор зохион байгуулна.

32.2.Энэ хууль батлагдсан өдрөөс өмнө байгуулагдан аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа явуулж байгаа тур оператор, аяллын агент, аялал жуулчлалын үйлчилгээний

байгууллага хамтран энэ хуулийн 27 дугаар зүйлд заасан нийтийн эрх зүйн хуулийн этгээдийг үүсгэн байгуулна.

32.3. Аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 32.1-д заасан хуралд оролцох байгууллагыг нээлттэй бүртгэх ба тур оператор, аяллын агент, аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагын зохистой харьцааг хангаж хурлыг зохион байгуулна.

32.4. Энэ хуулийн 6.5-д заасны дагуу тур оператор, аяллын агент нь 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор энэ хуулийн 27.1-д заасан нийтийн эрх зүйн хуулийн этгээдэд бүртгүүлнэ гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 1
Бүгд: 10
90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

68. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 33 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 1
Бүгд: 10
90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

69. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн “хөтөч” гэснийг “хөтөч-тайлбарлагч” гэж тохиолдол бүрд агуулгад нийцүүлэн өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 1
Бүгд: 10
90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

70. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн нэр томъёог жигдлэх, зүйл, хэсэг, заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх, бүтэц, найруулга, хууль зүйн техникийн засварыг хийх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 1
Бүгд: 10
90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Найруулгын санал:

Ц.Цэрэнпунцаг: 1. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “үндэсний онцлог бүхий байгаль” гэснийг “байгаль, үндэсний онцлог бүхий” гэж, 7 дугаар зүйлийн 7.1.4 дэх заалтын “худалдах,” гэснийг “худалдан” гэж, 10 дугаар зүйлийн 10.2.1 дэх заалтын “энгэрийн тэмдэг, үнэмлэхийг” гэснийг “үнэмлэх, энгэрийн тэмдэг” гэж, 16 дугаар зүйлийн 16.5 хэсгийн “хариуцсан” гэснийг “эрхэлсэн” гэж, 21 дүгээр зүйлийн

21.1.1 дэх заалтын, мөн 23 дугаар зүйлийн 23.1.1 дэх заалтын “төрийн” гэснийг “төрөөс баримтлах” гэж, 21.1.5 дахь заалтын “харилцааг” гэснийг “харьцааг” гэж, “23 дугаар зүйлийн 23.1.2 дахь заалтын “газар нутгийнхаа” гэснийг “нутаг дэвсгэрийнхээ” гэж, 24 дүгээр зүйлийн 24.1.1 дэх заалтын “бодлого, зорилтот хөтөлбөрийн” гэснийг “бодлогын” гэж, 24.1.14 дэх заалтын “жуулчин, аялагчийн” гэснийг “жуулчны” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 1

Бүгд: 10

90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийн “эрх,” гэснийг, 15 дугаар зүйлийн 15.5 дахь хэсгийн “аялагч болон” гэснийг, 16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсгийн “, аялагч” гэснийг, 22 дугаар зүйлийн 22.1.4 дэх заалтын “ажлыг хөгжүүлэх” гэснийг, 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсгийн “тухай” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 1

Бүгд: 10

90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.6 дахь заалтын “зохион байгуулах” гэсний өмнө “аялал” гэж, 7 дугаар зүйлийн 7.1.2 дахь заалтын “борлуулах” гэсний өмнө “худалдан” гэж, 21 дүгээр зүйлийн 21.2.4 дэх заалтын “аялал жуулчлалын” гэсний дараа “асуудлаар” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 1

Бүгд: 10

90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдтэй холбогдуулан боловсруулсан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Ц.Цэрэнпунцаг: 1.Ажлын хэсгийн гаргасан, Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн нэрийн “НЭМЭЛТ,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 1

Бүгд: 10

90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “374 дүгээр зүйлийн” гэсний дараа “374.1,” гэж, мөн зүйлийн “373.4 дэх хэсгийн “аялал жуулчлал” гэсний дараа “зохион байгуулагч” гэж, “372 дугаар зүйлийн 372.3 дахь хэсэг,” гэсний өмнө “372 дугаар зүйлийн

372.2 дахь хэсгийн “Аялал зохион байгуулагч” гэснийг “Тур оператор, аяллын агент” гэж,” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 1
Бүгд: 10
90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Ц.Цэрэнпунцаг: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 1
Бүгд: 10
90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Ц.Цэрэнпунцаг: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын “21 дүгээр зүйлийн 21.1.15 дахь заалт:” гэснийг “22 дугаар зүйлийн 22.5.12 дахь заалт:” гэж, мөн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 22 дугаар зүйлийн 22.9 дэх хэсгийн дугаарыг “22 дугаар зүйлийн 22.5.13 дахь заалт” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 1
Бүгд: 10
90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “22.9-д” гэснийг “22.5.13-д” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 1
Бүгд: 10
90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Ц.Цэрэнпунцаг: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөх.

“1 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хуулийн 10.14 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“10.14.Аялал жуулчлалын тухай хууль зөрчих

1. Тур оператор, эсхүл аяллын агентын үйл ажиллагааг эрхлэхдээ хуульд заасан бүртгэл хийлгээгүй бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2. Аялал жуулчлалын үйлчилгээний байгууллага нь үйлчилгээний стандарт, техникийн зохицуулалт, зэрэглэлд тавигдах шаардлагыг зөрчиж үйл ажиллагаа явуулсан бол хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 1
Бүгд: 10
90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Ц.Цэрэнпунцаг: 1. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 15 дугаар зүйлийн 15.5¹ дэх хэсгийн “нэг хоногоос” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 1
Бүгд: 10
90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 15 дугаар зүйлийн 15.5¹ дэх хэсгийн дугаарыг “15 дугаар зүйлийн 15.6 дахь хэсэг” болгож, мөн зүйлийн 2 дахь заалт буюу 15 дугаар зүйлийн 15.16, 15.17, 15.18 дахь хэсгийн дугаарыг “15 дугаар зүйлийн 15.17, 15.18, 15.19 дэх хэсэг” болгож, мөн зүйлийн 2 дахь заалтын 15.16 дахь хэсгийн, 15.17 дахь хэсгийн, 15.18 дахь хэсгийн “15.5¹ гэснийг “15.6” гэж, 15.18 дахь хэсгийн “15.16.4-т” гэснийг “15.17.4-т” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 1
Бүгд: 10
90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.9 дэх хэсгийн “15.5” гэсний дараа “, 15.6” гэж нэмсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 1
Бүгд: 10
90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн “эрхэлдэг” гэсний өмнө “хуулийн этгээд” гэж, “өөрчилсүгэй.” гэсний өмнө “, 15 дугаар зүйлийн 15.7 дахь хэсгийн “15.6-д” гэснийг “15.7, 15.5.18-д” гэж, мөн зүйлийн 15.6, 15.7, 15.8, 15.9, 15.10, 15.11, 15.12, 15.13, 15.14, 15.15 дахь хэсгийн дугаарыг “15.7, 15.8, 15.9, 15.10, 15.11, 15.12, 15.13, 15.14, 15.15, 15.16” гэж тус тус” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 1
Бүгд: 10
90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 1 дэх заалт нэмэх:

“1/13 дугаар зүйлийн 13.5.21, 13.5.22, 13.5.23 дахь заалт:

13.5.21.орон нутгийн агаарын тээврийн үйлчилгээ;
13.5.22.олон улс, орон нутгийн нисэх буудлын үйлчилгээ;
13.5.23.иргэний агаарын хөлгийн түрээсийн үйлчилгээ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 3
Татгалзсан: 7
Бүгд: 10
30.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Ганибал, Т.Энхтүвшин, Ш.Адьяа нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, Зам, тээврийн сайд С.Бямбацогт, Сангийн сайд Б.Жавхлан нар хариулж, тайлбар хийв.

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Ц.Цэрэнпунцаг: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Амьтны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Ц.Цэрэнпунцаг: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Ц.Цэрэнпунцаг: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйл буюу 29.1.12 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйл буюу 29.1.13 дахь заалтын “отоглох цэгээр” гэсний өмнө “улсын тусгай хамгаалалттай газар нутгаас бусад газарт байрлах” гэж нэмж, заалтын дугаарыг “29.1.12” болгож өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “29.1.13,” гэснийг “29.1.12,” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн “29.1.1-29.1.12 дахь заалт” гэснийг “29 дүгээр зүйлийн 29.1.1-29.1.11 дэх заалт” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Ц.Цэрэнпунцаг: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 1 дэх заалт нэмэх:

1/33 дугаар зүйлийн 4 дэх хэсэг:

“4.Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр байгаль хамгаалал, соёл, аялал жуулчлалыг дэмжихэд чиглэсэн үйл ажиллагаа явуулах шаардлагаар төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, нутгийн захиргааны байгууллага тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглахтай холбоотой харилцаанд энэ хуулийн 27.12-т

заасан журам үйлчлэхгүй бөгөөд хүсэлтийг үндэслэн гэрээ байгуулж ашиглуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 2 дахь заалт нэмэх:

2/33 дугаар зүйлийн 5 дахь хэсэг:

“5.Аялал жуулчлалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.10-д заасан аялал жуулчлалын дэд бүтцийг хөгжүүлэх, бий болгох зорилгоор газар ашиглах хүсэлт гаргасан иргэн, хуулийн этгээдэд газар ашиглах эрх олгоход мөн хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.6-д заасан төлөвлөгөөнд тусгагдсан газарт Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 10-т заасныг үндэслэн сонгон шалгаруулалтыг хялбаршуулсан журмаар энэ хуульд зааснаар явуулж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Дээрх саналтай холбогдуулан ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг үг хэлэв.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 3 дахь заалт нэмэх:

3/36¹ дүгээр зүйлийн 5 дахь хэсэг:

“5.Энэ хуулийн 33 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасан хялбаршуулсан журмаар сонгон шалгаруулалтыг явуулах тохиолдолд энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан тухайн тусгай хамгаалалттай газар нутгийн газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөг үндэслэхгүй байж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 4 дэх заалт нэмэх:

4/36² дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2 дахь заалт:

“2/Энэ хуулийн 33 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасан хялбаршуулсан журмаар сонгон шалгаруулалтыг явуулах тохиолдолд зарыг уг ажиллагааг явуулахаар товлосон

өдрөөс 10-аас доошгүй хоногийн өмнө цахимаар болон өдөр тутмын хэвлэлээр нийтэд мэдээлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 34 дүгээр зүйлийн 34.3 дахь хэсэг, мөн зүйлийн 2 дахь заалт буюу 40 дүгээр зүйлийн 40.1.3 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 36² дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2, 3 дахь заалтын дугаарыг “3, 4” гэж өөрчилсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дуусав.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 22 минут үргэлжилж, 18 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 55.5 хувийн ирцтэйгээр 17 цаг 40 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Ц.ЦЭРЭНПУНЦАГ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2023 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр,
Мягмар гараг Төрийн ордон “Жанжин
Д.Сүхбаатар” танхим 15 цаг 18 минут

**БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Ц.Цэрэнпунцаг: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

Хуралдаанд оролцож байгаа гишүүдийг танилцуулъя. Жамбалын Ганбаатар гишүүн, Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн, Польшийн Ерөнхийлөгч ирсэнтэй холбоотой уулзалтад оролцож байгаа юм байна.

Ингээд Тогмидын Доржханд гишүүн орон нутагт ажиллаж байна. Одонгийн Цогтгэрэл гишүүн орон нутагт ажиллаж байна. Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн, Чинбатын Ундрам гишүүн, Чимэдийн Хүрэлбаатар гишүүн, Баагаагийн Баттөмөр гишүүд гадаад томилолттой байна. ингээд бусад гишүүд хүрэлцэн ирж, өнөөдрийн хуралдааны ирц 55.6 хувьтай бүрдсэн тул Эдийн засгийн байнгын хорооны 2023 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлуудыг танилцуулъя.

Нэгдүгээрт, Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүд,

Хоёрдугаарт, Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүд гэсэн хоёр асуудал хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүд байна уу? Алга байна. Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё.

Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ гишүүн танилцуулна.

Бат-Эрдэнэ гишүүний микрофоныг нээе.

Ж.Бат-Эрдэнэ: Төмөр замын тээврийн тухай /Шинэчилсэн найруулга/ хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг хуулийн төсөлтэй холбогдуулан бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёолол, танилцуулгаа 2023 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн болон 04 дүгээр сарын 04-ний өдрүүдийн Байнгын хорооны хуралдаанд танилцуулж, хэлэлцүүлсэн билээ.

Нэгдсэн хуралдааны 2023 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн хуралдаанаар төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед төслийн анхны хэлэлцүүлгийг Байнгын хороогоор дахин явуулахаар шийдвэрлэсэн билээ.

Ажлын хэсэг болон ажлын дэд хэсэг 2023 оны 04 дүгээр сарын 06, 21, 25-ны өдрүүдэд хуралдан дараах асуудлыг төсөлд нэмж тусгах нь зүйтэй гэж үзлээ:

1. “Нийтийн зориулалттай төмөр зам”, “тусгай зориулалтын төмөр зам” гэсэн нэр томъёог “нийтийн төмөр зам”, “үйлдвэрлэлийн зориулалттай төмөр зам” гэж тус тус өөрчлөх;”

2. Хилийн тухай хуулиар тодорхойлсон “хилийн бүс”-д төмөр замын суурь бүтэц барихтай холбоотойгоор төсөлд тусгасан

зохицуулалтыг “хилийн зурвас газарт” гэж өөрчлөх;

3.Төмөр замын суурь бүтцийг төр, хувийн хэвшлийн түншилэлээр барих тохиолдолд түншилэлийн гэрээнд суурь бүтцийг төрийн өмчлөлд шилжүүлэх хугацаа, нөхцөлийг зайлигүй тусгаж өгөх бөгөөд энэ хугацаанд суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч нь тээвэрлэлтийн үйл ажиллагааг давхар эрхэлж болох зохицуулалтыг төсөлд тусгах.

Ажлын хэсгийн саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Ц.Цэрэнпунцаг: Ажлын хэсгийг танилцуулъя. Б.Жавхлан Зам, тээврийн хөгжлийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэлтсийн дарга, С.Мяндасмаа Зам, тээврийн хөгжлийн яамны Хуулийн хэлтсийн дарга, Итгэлт Зам, тээврийн хөгжлийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Төмөр замын тээврийн хэлтсийн дарга, Л.Булганхүү Зам, тээврийн хөгжлийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах шинжээч.

Ажлын хэсгийн танилцуулгаас асуух асуулттай Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү? Алга байна. Асуулттай гишүүд байхгүй байгаа тул Байнгын хорооны өмнөх хуралдаанаар санал хурааж шийдвэрлэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор ахин санал хураалт явуулах шаардлагагүй. Тиймээс ажлын хэсгийг дахин хэлэлцүүлэхээр бэлтгэсэн саналын томъёоллуудаар санал хураалт явуулж эхэлье.

Төмөр замын тээврийн тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн төслийн талаар ажлын хэсгээс бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёолол

1.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.7 дахь заалт буюу “нийтийн зориулалттай төмөр зам”, 4.1.8 дахь заалт буюу “тусгай зориулалтын төмөр зам” гэсэн нэр томъёог доор дурдсанаар өөрчлөн найруулж, төсөлд тусгагдсан эдгээр нэр томъёог тохиолдол бүрд нийцүүлэн өөрчлөх:

“4.1.7. “нийтийн төмөр зам” гэж нийтэд тээврийн үйлчилгээ үзүүлэх зориулалт бүхий төмөр замын суурь бүтцийг;

4.1.8. “үйлдвэрлэлийн зориулалттай төмөр зам” гэж аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд зориулагдсан төмөр замын суурь бүтцийг;”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ, А.Адъяасүрэн, Э.Бат-Амгалан, Б.Баттөмөр, Б.Жавхлан, М.Оюунчимэг, С.Чинзориг /цаашид “Ажлын хэсэг” гэх/.

Гишүүд анхааралтай байгаарай.

Энэ техникийн саатал гараад байгаа учраас Жавхлан сайд та горимын санал гаргах уу?

Жавхлан гишүүний микрофоныг өгье.

Б.Жавхлан: Цэрэнпунцаг дарга аа баярлалаа. Техникийн юм нь болохгүй байгаа юм уу. Яагаад байгаа юм. Өмнө нь бас ингээд байсан. Картаа хийсэн чинь бүх цахилгаанууд нь масс өгөөд ирцнээс бүр сая гарч ороод, хуруу уншигдахгүй байгаад байна. Тийм учраас нэгэнт ирц бүрдсэн байгаа юм чинь санал хураалтаа илээр хурааж өгнө үү гэсэн горимын санал гаргаж байна. Горимын санал дээр санал хурааж өгнө үү. Баярлалаа.

Ц.Цэрэнпунцаг: Жавхлан гишүүний горимын саналыг үндэслээд Дэгийн тухай хуулийн 14.4-т заасны дагуу

илээр санал хураалт явуулъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Сая би саналыг томъёоллыг уншаад танилцуулсан санал хураалт явуулъя.

Санал хураалт. Гишүүдийн 70 хувь нь дэмжиж саяын горимын санал дэмжигдлээ.

Ингээд горимын санал дэмжигдсэн тул үүнээс цааших санал хураалтаа гар өргөж илээр хурааа.

Минийхийг протоколд тэмдэглээрэй. Дэмжиж өгсөн шүү.

Зарчмын зөрүүтэй саналын саналын томъёоллыг би түрүүн уншиж танилцуулсан. Ингээд санал гаргасан ажлын хэсгийг танилцуулсан. Цаашид ажлын хэсэг гэнэ гээд.

Ингээд санал хураалт явуулъя. Зарчмын зөрүүтэй саналын 1 дүгээр томъёоллоор санал хураалт явуулъя.

8 гишүүн дэмжиж, 80 хувийн санал саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 7 дугаар зүйлийн 7.1.5 дахь заалтын “30 дугаар зүйлийн 30.1-т заасан хилийн бүсэд” гэснийг “26.1-д заасан хилийн зурваст” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

10-аас 8 гишүүдийн 80 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

3.Төслийн 24 дүгээр зүйлийн 24.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“24.3.Төмөр замын суурь бүтцийг төр, хувийн хэвшлийн түншилэлээр барих тохиолдолд суурь бүтцийг төрийн өмчлөлд шилжүүлэх хугацаа, нөхцөлийг

түншилэлийн гэрээнд тусгах бөгөөд түншилэлийн хугацаанд суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч нь тээвэрлэгчийн үйл ажиллагаа эрхэлж болно.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

10-аас 8, гишүүдийн 80 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

4.Найруулгын санал:

Төслийн 11.1.10 дахь заалт болон 31.3 дахь хэсгийн “зориулалттай” гэсний өмнө “тээврийн” гэж, 25.1.6 дахь заалтын “хангах” гэсний өмнө “мэдээллээр” гэж тус тус нэмэн, 4.1.3 дахь заалтын “үйлчилгээ үзүүлэх” гэснийг “үйл ажиллагаа эрхлэх” гэж, 4.1.22 дахь заалтын “сэлгээний ажлыг” гэснийг, “сэлгээний хөдөлгөөнийг” гэж, 4.1.23 дахь заалтын “нэг түвшинд” гэснийг “ижил түвшинд” гэж, 9.1.3 дахь заалтын “олгох” гэснийг “ашиглуулах” гэж, 20.3 дахь хэсгийн “сүлжээг хөгжүүлэхэд” гэснийг “сүлжээний төлөвлөлтөд” гэж, 26.4 дэх хэсгийн “аливаа этгээдэд” гэснийг “бусдад” гэж, 36.4.5 дахь заалтын “ачаа” гэснийг “, дутсан ачаа” гэж тус тус өөрчлөн, 32.7 дахь хэсгийн “өмчлөгч,” гэснийг хасах.-Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

10-аас 8 гишүүдийн 80 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

5.Дээрх саналуудтай нийцүүлэн Байнгын хорооны 2023 оны 03 дугаар сарын 28, 04 дүгээр сарын 04-ний өдрийн хуралдаанаар дэмжигдсэн саналын томъёоллын 24.2-т тусгагдсан “нийтийн зориулалттай төмөр замд” гэсэн нэр томъёог “нийтийн төмөр замд” гэж, 32.1-д тусгагдсан “сэлгээний ажил” гэснийг “сэлгээний хөдөлгөөн” гэж, 9.1.5-д тусгагдсан “эзэмшүүлэх” гэснийг “эзэмших, ашиглах” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

10-аас 8 гишүүдийн 80 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Төмөр замын тээврийн тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол:

1.Байнгын хорооны 2023 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаар төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед дэмжигдсэн “1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 14.10 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн “эзэмшигч нь” гэсний өмнө “өмчлөгч,” гэж нэмэх” гэсэн саналыг хүчингүй болгох. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

10-аас 8 гишүүдийн 80 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 14.10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “мянган” гэсний өмнө “нэг” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

10-аас 8 гишүүдийн 80 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй нэмэлт саналуудаар санал хураалт явуулж дууслаа.

Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг дахин явуулж дууслаа.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг дахин явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг

чуулганы нэгдсэн хуралдаанд ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ уншиж, танилцуулна.

Дараагийн асуудалд оръё. Дараагийн ажлын хэсгийг оруулж ирээрэй.

Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг танилцуулна.

Ганхуяг гишүүний микрофоныг нээе.

Х.Ганхуяг: Аялал жуулчлалын хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулга Засгийн газраас аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт 12 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг өргөн мэдүүлсэн.

Төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг нэгдсэн чуулганы 2022 оны 12 дугаар сарын 8-ны өдөр хийж анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн. Эдийн засгийн байнгын хорооны 2023 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн хуралдаанд ажлын хэсгийн танилцуулгыг дэлгэрэнгүй танилцуулсан. Тус хуралдаанаар Аялал жуулчлалын тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд холбогдон Засгийн газраас санал ирүүлэх шаардлагатай гэж үзсэн тул хуулийн төслүүдийн хэлэлцүүлгийг хойшлуулсан. ЗГХЭГ-ын даргын 2023 оны 4 дүгээр

сарын 14-ний өдөр тус хуулийн төсөлтэй холбогдуулан санал ирүүлсэн. Ажлын хэсэг Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан боломжит хүрээнд багцлан 67 зарчмын зөрөөтэй санал, 3 найруулгын санал хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдтэй холбогдуулан 23 зарчмын зөрөөтэй санал нийт 93 зарчмын зөрүүтэй саналын томъёолол бэлтгэн та бүхэнд тараасан болно оо.

Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаарх ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхэн хүсэж байна. Баярлалаа.

Ц.Цэрэнпунцаг: Ажлын хэсгийг танилцуулъя. Бат-Өлзийн Бат-Эрдэнэ БОАЖ-ын сайд, Сүхбаатарын Цогтгэрэл Байгаль орчин, аялал жуулчлалын яамны ТНБД, Төгсгэрэлийн Мөнхбат Байгаль орчин, аялал жуулчлалын яамны аялал жуулчлалын бодлого зохицуулалт зохицуулалтын газрын дарга, Бямбарагчаагийн Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Нармандахын Жамьянхүү Хууль зүй, дотоод хэргийн яамны ахлах шинжээч, Ренчинпүрэвийн Лхагвабаяр Монголын Эрх зүй судалгаа хөгжлийн төв ТББ-ын хуульч судлаач.

Ажлын хэсгийн танилцуулгаас асуух асуулттай Улсын Их Хурлын гишүүд нэрсээ өгнө үү?

Энхтүвшин гишүүнээр тасаллаа. Ганибал гишүүний микрофоныг нээе.

Н.Ганибал: Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын маш олон зарчмын зөрүүтэй санал орж ирж байна л даа. Би энэ концепцын хувьд яг ямар ямар өөрчлөлтүүд орсон талаар бас ажлын хэсгийн даргаас асууцхъя.

Жишээлбэл бас яг нэг хэлэлцэх үеэр нэлээдгүй бас асуудал үүсгээд байсан аялал жуулчлалыг сурталчлах гээд аялал жуулчлалын сан гэж байгуулах тухай байсан. Энэ өнөөдөр энэ зарчмын зөрөөтэй саналууд дотор яг ямар найруулгаар орж ирээд байна вэ гэдгийг асууцхъя.

Мөн нөгөө аялал жуулчлалын отог гээд. Тэр асуудал бас нэг томъёолол нь буруугаас болоод бас хэл ам татлаад байх шиг байсан л даа. Энэ дээр нөгөө аялал жуулчлалын компаниудад газар олгох гээд байна энэ тэр гэсэн асуудал байгаа.

Энийг яг албан ёсоор яаж томъёолж өмнөх хуулиас ялгаатай нь тэр асуудал нь юу байгаа юм. Хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх тал дээр яг бодитой ямар заалтууд бас энэ өөрчлөлт дотор орж ирж байна гэсэн асуудлууд байна аа? Тэгээд дээрээс нь бас энэ нөгөө нэг хөтчийн асуудлууд байгаа. Хөтчийн асуудлууд дээр ер нь зүгээр бусад улс орнуудыг харахад ер нь тодорхой аялал жуулчлалын сурталчилгаа тайлбар хийх гэж байгаа хүмүүс нь тухайн байгууллага нь ч юм уу нэг эсвэл аялал жуулчлалын холбооноос тэр л асуудлаар нь сургалт хийгээд тэгээд тухайн асуудал дээр нь хөтөч хийх тийм албан ёсны зөвшөөрөл боломжуудыг олгодог л доо. Тэгээд яг энэ өнцгөөсөө орж ирсэн үү?

Түрүүн нэг харж байсан тэр 28 дээр аялал жуулчлалын сургууль дээд мэргэжилтэй гээд бараг заачихсан байв уу даа. Тэгэх юм бол нөгөө энэ аялал жуулчлалаар сурч байгаа оюутан залуучууд, дээрээс нь аялал жуулчлалын мэргэжилтэй гээд заачихсан байна л даа. Тэгээд яах вэ эсхүл гээд тодотгосон байх шиг байна.

Тэгээд яг тэр нь яг яаж орж ирснийг нь бас тодотгож өгөөч. 26 дээр байх шиг байна. Тэгээд аль болох 1 хялбар гэхдээ нөгөө мэдээллээ мэддэг гаднынханд юмаа тайлбарлаж чаддаг энэ л хүмүүсийг

хөтөч гэдэг байдлаар асуудалд томъёолж өгөх нь зөв байх гэсэн саналтай байна.

Энэ хэд дээр санал хариулт авчихъя.

Ц.Цэрэнпунцаг: Ажлын хэсгийн ахлагч Ганхуяг гишүүн хариулъя.

Х.Ганхуяг: Гишүүний асуултад хариулъя.

Нэгдүгээрт бол энэ отоглох цэгтэй холбоотойгоор яг хуулийн хэлэлцэх хэсэг дээр нөгөө зөвшөөрөлгүй газар отогловол торгуультай байх заалтууд орж байсан юм. Тэгээд тэр бол Зөрчлийн хуулиас нь дээрх заалтуудыг хассан байгаа. Энэ дээр бол одоо отоглох цэгийг зөвхөн нь аялал жуулчлалын бүсэд хамаарах асуудал байдлаар зохицуулсан байгаа. Энэ бүхэлдээ аялал жуулчлалыг бодлогын хувьд яаж дэмжих вэ гэдэг л хууль гэсэн үг. Ер нь бол аялал жуулчлалыг яаж хөгжүүлэх вэ гэдэг асуудалд хариулна гэсэн үг. Энэ дээр бол сан байхаар бол анх орж ирсэн.

Тэгэхдээ сан нь бол казиногийн 5%, морин тойруулгын 5% дээрээс нь навигацын нөгөө улсын төсөвт төвлөрсөн орлогын 20% гэдэг байдлаар орж ирсэн юм. Тэгээд тэрийг яагаад энэ сан байхгүй болгосон бэ? Энэ нөгөө сангийн асуудлыг хассан бэ гэхээр угаасаа нөгөө 2 хууль нь батлагдаагүй байхгүй юу. Тэгээд ямар нэгэн байдлаар сан байгуулж улсын төсвийн аль 1 орлогыг багцалж ингэж сан дээр ингээд төвлөрүүлдгийг больё гэсэн байдалтайгаар ер нь Эдийн засгийн байнгын хороон дээр ч энэ асуудлыг ярьсан. Өмнө нь ч гэсэн бусад Байнгын хороод ч гэсэн энэ асуудал яригдаад байгаа юм. Тэгээд энэ Эдийн засгийн байнгын хороон дээр сангуудыг шалгах ажлын хэсэг байгуулагдсан явж байгаа. Тэгэхээр цаашид бол зүгээр улсын төсвөөрөө энэ дэмжих асуудлууд хийгээд явъя гэдэг зарчмын зөрүүтэй энэ том асуудал орж ирж байна гэсэн үг.

Хоёрдугаарт бол энэ хуулиар бол бид нар нөгөө нийтийн эрх зүйн хуулийн этгээд буюу ТББ байгуулах юм. Хуулийг хуулиар. Тэнд нь болохоор тэр аялал жуулчлалын компаниуд нь, түр операторууд нь, түр агентууд нь, таны ярьж байгаа асуугаад байгаа хөтчүүд нь ч гэсэн тэндээ орно гэсэн үг. Тэгээд дотроо өөрснөө бүртгэлээ хийнэ, ангиллаа хийнэ. Дээрээс нь одоо тэр мэргэжлийн хүмүүсээ мэргэжил дээшлүүлэх байдлаа мэргэшүүлэх байдлаар хүмүүсээ бэлдэнэ сургалтуудаа явуулна гэсэн үг.

Хөтөч дээр яагаад энэ боловсролын асуудал хөндөгдөж байна гэхээр ерөнхийдөө аялал жуулчлалын гол яг тэр хүмүүстэй, гаднын хүмүүстэй харьцаж байдаг хүн нь л хөтөч байхгүй юу. Тэр Монголын түүхээ мэддэг байх, тэр нөгөө байгаль орчноо мэддэг байх, нөгөө газар нутгаа мэддэг байх гэх мэтээр. Тэр юун дээрээ тодорхой хэмжээний мэргэшүүлэх асуудал хөндөгдөх ёстой байгаа. Тийм болохоор энэ нь орж байгаа шүү.

Хил орчмын аялал жуулчлалтай холбоотойгоор бол хил орчмын аялал жуулчлалын маршрутыг аялал жуулчлал эрхэлсэн сайд, Хууль зүйн сайд хамтарч гаргах юм байгаа юм. Тэгээд тэр орчимд нь болохоор гэрээний үндсэн дээр энэ түр операторуудаас аяллыг зохион байгуулах юм. Тийм учраас нийтийн эрх зүйн этгээд дээр энэ улсуудаа бүгдийг нь бүртгэл түр оператор түр агентлаг дээр нь ангилж бүртгэ гээд байгаа байхгүй юу. Тэгээд тиймэрхүү байдлаар.

Нөгөө дараа нь нэмж юу асуулаа, болчихсон уу тэ.

Ц.Цэрэнпунцаг: Энхтүвшин гишүүн асуултаа асууя.

Т.Энхтүвшин: Баярлалаа. Энэ хил орчмын аялал жуулчлал гээд ингээд Ганхуяг гишүүн ээ хил орчмын аялал жуулчлал гээд ингээд нэр усаар нь

оруулаад ирдэгт бас их баярлаж байна аа. Тэгээд энэ хил орчмын аялал жуулчлалд хэн аялж жуулчилдаг вэ гэхээр нөгөө 2 хөрш маань л байгаа шүү дээ. Оросын холбооны иргэд, БНХАУ-ын иргэд л хил орчмын аялал жуулчлалыг хийдэг. Тэгээд өнөөдөр ингээд хил орчмын аялал жуулчлал гээд яг нэр томъёогоор нь оруулаад ирсэн байна. Тэгээд энэ хуулийн бас нэг дэвшилттэй тал нь бас энэ юм болов уу гэж би бас харж байна.

Хуучин бол юу гэдэг юм 2015 онд нэг өдрийн аялал жуулчлал гээд энэ хил орчмын аялал жуулчлал нэлээн идэвхтэй явж байсан юм л даа. Өглөө орж ирээд хилийн багана дээр нэг 6 авхуулаад, Монгол хоол идээд, дэлгүүр хоршоо хэсээд тэгээд 4, 5 цагийн алдад буцаад гарчихдаг ийм аялал жуулчлал байсан. Харамсалтай нь Асем болно гээд хаагдаж байсан. Та бүхэн мэдэж байгаа байх. Тэрнээс хойш бол энэ хил орчмын аялал жуулчлал буюу 1 өдрийн аялал жуулчлал ингээд хэрэгжээгүй явсан. Ингээд нэр усаараа ороод ирсэнд нэлээн их ач холбогдолтой хууль болжээ гэж ингэж харж байна.

Хоёр дахь асуух асуулт бол ерөөсөө энэ хууль дээр байгаад байна л даа. Энэ гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжинэ гээд биччихсэн байна. Зохистой харилцааг бий болгох гээд. Тэгээд энийг одоо яаж бий болгох юм. Гаднын хөрөнгө оруулалтыг энэ аялал жуулчлалын салбар руу яаж түлхүү оруулж ирэх талаар ямар бодлого барьж байгаа юм. Энэ хууль дээр яг ямар заалтууд бас тусгагдсан байна гэдгийг бас асуумаар байж байна.

Бүс нутгийн аялал жуулчлал гээд сүүлийн жилүүдэд бас нэлээн яригдаж байгаа. Ялангуяа бүс нутгийн аялал жуулчлал гээд нэг олон хоногоор биш 3 хоногоор, 4 хоногоор, 7 хоногоор орж ирдэг ийм аялал жуулчлал байдаг. Энэ дээр юу гэдэг юм ямар юу гэдэг юм хөнгөлөлттэй болон ямар дэмжсэн ийм бодлого ийм хууль дээр тусгагдсан байгаа вэ? Энэ дээр ямар ч байсан нэг хариулт аваадахъя.

Ц.Цэрэнпунцаг: Ажлын хэсгээс хэн хариулах вэ? Ажлын хэсгийн ахлагч Ганхуяг гишүүн хариулъя.

Х.Ганхуяг: Энхтүвшин гишүүний асуултад хариулъя.

Тийм хил орчмын ер нь бол яах вэ бид нар нөгөө жуулчдын тоогоо ихэсгэе ээ гэж бодох юм болбол яг одоогийн өнөөдрийн нөхцөл байдлаар гүний жуулчид буюу яг шинэ нисэхээр үйлчлүүлэх жуулчид гэх юм бол максимумдаа сая жуулчин л авах юм байна лээ. Өнөөдөр яг үйлчлүүлж байгаа шинэ онгоцны шинэ нисэхээр үйлчлүүлж байгаа хүний тоо нь сая байхгүй юу. Тэгээд тэрнийх нь 500000 нь дотоодын нисгэгч, 500000 нь гадаадын хүмүүс байгаа юм.

Энэ шинэ нисэхийн хүчин чадал нь өөрөө 1500000-ын хүчин чадалтай. Тэгэхээр бид нар зүгээр эргээгээд эргээгээд саяас илүү хүн авахгүй юм байна лээ. Тэгэхээр 1 ёсондоо 500000-аар л жуулчнаа нэмэгдүүлэх боломжтой. Хамгийн их жуулчин авч байсан жил нь 2019 онд юм байна лээ. Тэр чинь нэг 500000-аад жуулчин авсан. Манай улсын эдийн засагт 200-аад сая долларын мөнгө оруулсан юм байдаг юм байна лээ. Тэгээд тэр 500 мянгынх нь 150000 нь Оросоос, 150000 нь Хятадаас ингээд л орж ирсэн байдаг юм байна лээ. Тэгэхээр бид нар бол өндөр өсөлтийг юунаас бий болгох боломжтой гэхээр энэ хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлснээр бий болгох боломжтой юм байна лээ.

Тэгээд энийгээ харин дараа дараагийн тэр казиногийн хууль ч байдаг юм уу эд нарыгаа хийхдээ энэ хил орчимд тэр казиногийнхоо асуудлыг шийдчихвэл нөгөө тэр орж ирж байгаа хүмүүсээс энэ мөнгөө авч энэ эдийн засагт үлдэх нэг тийм бас хөшүүрэг болох юм байна лээ шүү гэдгийг анхааруулчихмаар юм байна лээ. Энэ Засгийн газрын таны асуулт дээр энэ чиг үүрэг дээр яг тэр зохистой

харьцааг хангах асуудлыг оруулж өгч байгаа юм.

Дээрээс нь хууль дээр нөгөө улсын аялал жуулчлалын бүс орон нутгийн аялал жуулчлалын бүс байж болохоор тусгагдаж байгаа гэсэн үг. Засгийн газрын үүрэг буюу энэ Байгаль орчин, аялал жуулчлалын яамны үүрэг бол тэр аялал жуулчлалын дэд бүтцийн ерөнхий төлөвлөгөө гэж юмаа боловсруулаад Засгийн газраар батлуулах ёстой юм. Тэгээд нэг ёсондоо аялал жуулчлалын бүсүүдтэй холбогдсон аялал жуулчлалын дэд бүтцийг засаг өөрөө хийнэ гэсэн үг. Тэгээд хийхдээ төр хувийн хэвшлийн түншлэлийн хэлбэрээр улсын төсвөөс гэсэн байдлаар хийнэ гэсэн үг. Магадгүй гадаадын зээл тусламж гээд. Тэгээд тэр аялал жуулчлалын бүс доторх тэр хөрөнгө оруулалтыг татах асуудал энэ манай энэ салбарын аялал жуулчлалыг харцуцаж байгаа яам болон тэр нийтийн эрх зүйн хуулийн этгээдийнхэн нь хамтарч хийнэ ээ л гэсэн үг. Баярлалаа.

Ц.Цэрэнпунцаг: Ажлын хэсгээс ажлын хэсгийн микрофон хэдэн номер дээр байгаа юм. Ажлын хэсгийн 2 номер гэгчихвэл яадаг юм. 2 номер дээр хариулъя.

Б.Бат-Эрдэнэ: Энхтүвшин гишүүний асуултад хариулъя.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Бат-Эрдэнэ. Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулга 19.2.1 дээр Улсын аялал жуулчлалын бүс, улсын аялал жуулчлалын 19.3 дээр улсын аялал жуулчлалын бүсийг тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх аялал жуулчлалын салбарт хөрөнгө оруулалтыг дэмжих, байгаль түүх, соёлын өв, аялал жуулчлалын нөөцийг хамгаалах зорилгод нийцүүлэн улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд үндэслэн Засгийн газраас тогтоож хил заагийг батална гэсэн ийм заалт байгаа. Үүний дагуу 22.1.8 дээр аялал жуулчлалын үйлчилгээний салбарт олон улсын стандартыг нэвтрүүлж байгаа аялал

жуулчлалын байгууллагыг бодлогоор дэмжих гэдэг ийм заалт орсон байгаа.

Өөрөөр хэлбэл улсын аялал жуулчлалын бүсийн хил заагийг Засгийн газраас тогтоож батлаад түүнийхээ дагуу гадаадын хөрөнгө оруулалтыг оруулж ирэх процессыг болбол аль болох Засгийн газар баталгаа гаргаж ажиллаж баталгаа гаргах ч юу байх вэ Засгийн газар бол дэмжиж ажиллана л гэсэн үг. Хууль эрх зүйн орчин бол Хөрөнгө оруулалтын тухай хуулиараа шийдвэрлэгдэж байгаа.

Ц.Цэрэнпунцаг: Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрөөтэй саналуудаар санал хураалт явуулж эхэлье ээ.

Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаарх зарчмын зөрөөтэй саналын томъёолол.

Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “аялал жуулчлалын үйлдвэрлэлээр эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, дэмжихтэй холбогдсон болон” гэснийг “аялал жуулчлалыг хөгжүүлэх, нийгэм, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх,” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, Ш.Адъяаа, Х.Булгантуяа, Т.Доржханд, М.Оюунчимэг /цаашид “Ажлын хэсэг” гэх/. Дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Гишүүдийн 90 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “энэ хууль тогтоомжоос” гэснийг “Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль

тогтоомжийн бусад актаас” гэж өөрчлөх. Дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Гишүүдийн 90 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

3.Төслийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.1.Энэ хуулиар Монгол Улсын нутаг дэвсгэр дэх аялал жуулчлалын үйл ажиллагааг зохицуулна.

3.2.Тусгай хамгаалалтай газар нутаг дахь аялал жуулчлалын үйл ажиллагааг энэ хууль болон Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулиар зохицуулна.” Дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Гишүүдийн 90 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

4.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтын “нэг хоногоос” гэснийг, 4.1.4 дэх заалтын “2, түүнээс дээш” гэснийг, 4.1.6 дахь заалтын “жижиглэн, эсхүл хоёр, түүнээс дээш бүтээгдэхүүн, үйлчилгээг багцлан,” гэснийг тус тус хасах. Дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Гишүүдийн 90 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

5.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.11 дэх заалтын “аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг эрхлэхэд шаардагдах газрын гадаргуу дээрх” гэснийг “үйл ажиллагаанд ашиглах” гэж өөрчилж, “археологи” гэсний өмнө “палеонтологи” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Гишүүдийн 90 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

6.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.10 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.10.“аялал жуулчлалын дэд бүтэц” гэж нисэх буудал, зам, тээвэр, эрчим хүч, ус хангамж, ариун цэврийн байгууламж, улсын, олон улсын болон орон нутгийн чанартай авто зам дагуух үйлчилгээний байгууламж, тэмдэг тэмдэглэгээ, харилцаа, холбоо, мэдээлэл технологийн цахим дэд бүтцийг;” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Гишүүдийн 90 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

7.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.2.“жуулчин” гэж энэ хуулийн 4.1.1-д заасан аялал жуулчлалын үйл ажиллагаанд хамрагдаж байгаа хүнийг;” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Гишүүдийн 90 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

8.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.5.“аялал жуулчлалын үйлчилгээний байгууллага” гэж байр сууц, тээвэр, хоол үйлдвэрлэл, үзмэр, үзвэр үйлчилгээ, жуулчны мэдээллийн төв зэрэг жуулчинд зориулсан үйлчилгээ эрхэлж байгаа хуулийн этгээдийг;” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Гишүүдийн 90 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

9.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.7 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.7. “аяллын агент” гэж тур оператор болон аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагын бүтээгдэхүүн, үйлчилгээг зуучлан борлуулж байгаа хуулийн этгээдийг;” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Гишүүдийн 90 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

10.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.9 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.9. “тусгай сонирхлын аялал жуулчлал” гэж тусгай мэргэжлийн ур чадвар, техник хэрэгсэл шаардсан аялал жуулчлалыг;” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Гишүүдийн 90 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

11.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Гишүүдийн 90 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

12.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“4.1.12. “нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал” гэж тухайн орон нутгийн иргэд, нөхөрлөл жуулчинд

энэ хуулийн 11.1-д заасан бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлэхийг;” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Гишүүдийн 90 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

13.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“4.1.13. “отоглох цэг” гэж аялал жуулчлалын эрэлт, байгаль орчны даацад нийцүүлэн хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэхэд зориулагдсан, өөрийн стандарт бүхий, жуулчинд зориулсан түр байрлах үйлчилгээний цогц орчныг;” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Гишүүдийн 90 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

14.Төслийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн “бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх, тэдгээрийг хэрэглэгчдэд хүргэх үйлдвэрлэл, үйл ажиллагаа нь аялал жуулчлалын” гэснийг “үйлдвэрлэл нь” гэж, мөн зүйлийн 5.2.3 дахь заалтын “бүтээгдэхүүн” гэснийг “бүтээгдэхүүн, үйлчилгээ” гэж, 5.3.3 дахь заалтын “урлаг, үзвэр үйлчилгээ” гэснийг “үзмэр болон урлаг” гэж, мөн зүйлийн 5.4 дэх хэсгийн “энэ хуулийн 5.2, 5.3-т заасан аялал жуулчлалын байгууллагын гадаадын жуулчинд үзүүлсэн үйлчилгээ” гэснийг “аялал жуулчлалын байгууллагын гадаадын жуулчинд үзүүлсэн энэ хуулийн 5.2, 5.3-т заасан үйлчилгээ” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Ганхуяг гишүүн саналаа хэлье.

Х.Ганхуяг: Энэ дээр даргаа үзмэр болон урлаг гэдгийн өмнө спортын арга хэмжээ гэж нэмэх гээд. Яагаад гэхээр нөгөө бид нар чинь нөгөө сагсан

бөмбөгийн Азийн аварга шалгаруулах урьдчилсан шалгаруулах тийм энэ ажлын хэсгийн юун дээр энэ орхигдуулчихсан байна тэгээд энийг нэмээд оруулчихъя гэж байхгүй юу. Спортын арга хэмжээ үзмэр болон урлаг гээд. Үзмэр болон урлагийн өмнө спортын арга хэмжээ гээд оруулчихаад байгаа юм.

Ц.Цэрэнпунцаг: Би дахиад 14-ийг. Би дундаас нэмээд уншихъя. 5.3.4 дэх заалтын урлаг, үзвэр үйлчилгээ гэснийг спортын арга хэмжээ үзмэр болон урлаг гэж уншлаа.

Ингээд энүүгээр томъёололдоо авчхаарай. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Гишүүдийн 90 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

15.Төслийн 5.3.4 дэх заалтын “худалдаа” гэсний өмнө “жуулчинд зориулсан гар урлалын болон бусад” гэж нэмж, төслийн 5.3.5 дахь заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Гишүүдийн 90 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

16.Төслийн 6 дугаар зүйлийн 6.3, 6.8 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Гишүүдийн 90 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

17.Төслийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсгийн “6.2-т заасан ангилалд тусгагдаагүй байгууллага тусгай сонирхлын болон бусад төрлийн эрсдэл бүхий аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэх” гэснийг “6.2.1, 6.2.2-т зааснаас бусад байгууллага эрсдэл бүхий аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ

үзүүлэх” гэж, 6.9 дэх хэсгийн “соёлын биет өв буюу түүх, соёлын үл хөдлөх болон хөдлөх дурсгалт зүйлийн” гэснийг “соёлын биет өвийн” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Гишүүдийн 90 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

18.Төслийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.1.1.аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг төлөвлөн бүрдүүлж, шууд, эсхүл аяллын агентаар дамжуулан худалдан борлуулах, аялал зохион байгуулах;” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Гишүүдийн 90 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

19.Төслийн 7 дугаар зүйлийн 7.2.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.2.2.аялал жуулчлалын мэдээллийн санд үйл ажиллагааныхаа статистик мэдээллийг маягтын дагуу тогтоосон хугацаанд ирүүлэх;” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Гишүүдийн 90 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

20.Төслийн 7 дугаар зүйлийн 7.2.7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.2.7.бүтээгдэхүүн, үйлчилгээ болон байгууллагынхаа үйл ажиллагааны талаар мэдээлэл авах боломжийг цахим орчинд бүрдүүлсэн байх;” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Гишүүдийн 90 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

21.Төслийн 7 дугаар зүйлийн 7.2.1 дэх заалтын “түүх,” гэснийг “хууль тогтоомж, түүх, соёл,” гэж, 7.2.6 дахь заалтын “хэлбэрийг хөгжүүлэх” гэснийг “бүтээгдэхүүн, үйлчилгээг үзүүлэх” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Гишүүдийн 90 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

22.Төслийн 7 дугаар зүйлийн 7.1.5 дахь заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Гишүүдийн 90 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

23.Төслийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтын “бүтээгдэхүүнийг” гэснийг “болон аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагын бүтээгдэхүүн, үйлчилгээг” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Гишүүдийн 90 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

24.Төслийн 8 дугаар зүйлийн 8.1.3 дахь заалт, мөн зүйлийн 8.2 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Гишүүдийн 90 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

25.Төслийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, мөн зүйлийн 9.2.2, 9.2.4, 9.2.5 дахь

заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Гишүүдийн 90 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

26.Төслийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийн “Хөтөч” гэсний өмнө “Аялал жуулчлалын мэргэжилтэй, эсхүл” гэж, мөн зүйлийн 10.2.2 дахь заалтын “үндэсний” гэсний өмнө “хууль тогтоомж,” гэж, 10.3 дахь хэсгийн “журмыг” гэсний өмнө, мөн 10.4 дэх хэсгийн “чиг үүргийг” гэсний өмнө “болон мэргэжлийн ур чадварын зэрэглэл тогтоох” гэж тус тус нэмж, мөн 10.4 дэх заалтын “журмын дагуу” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Гишүүдийн 90 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

27.Төслийн 10 дугаар зүйлийн 10.5 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Гишүүдийн 90 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

28.Төслийн 11 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“11 дүгээр зүйл.Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал

11.1.Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалд жуулчинд зориулсан дараах бүтээгдэхүүн, үйлчилгээ хамаарна:

11.1.1.нүүдэлчдийн соёл, ахуй, зан заншлыг танилцуулан сурталчлах;

11.1.2.зочны гэрээр үйлчлэх;

11.1.3.ердийн хөсгөөр үйлчлэх;

11.1.4.энэ хуулийн 5.3-т заасан аялал жуулчлалын дагалдах бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлэх.

11.2.Төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал хөгжүүлэхийг дэмжиж ажиллана.

11.3.Улсын болон орон нутгийн аялал жуулчлалын бүсэд нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал эрхлэхэд энэ хуулийн 19.16-д заасан бүсийн төлөвлөлтийг баримтална.

11.4.Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг эрхлэгч нь эрх бүхий байгууллагаас баталсан техникийн зохицуулалт, стандартыг үйл ажиллагаандаа мөрдөнө.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Гишүүдийн 90 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

29.Төслийн 12 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“12 дугаар зүйл.Тур операторын бүртгэл

12.1.Энэ хуулийн 6.5-д заасны дагуу тур операторыг дараах ангиллаар бүртгэнэ:

12.1.1.Монгол Улсаас бусад улс руу хийх аялал жуулчлалын үйлчилгээ;

12.1.2.бусад улсаас Монгол Улс руу хийх аялал жуулчлалын үйлчилгээ;

12.1.3.энэ хуулийн 12.1.1 болон 12.1.2-т заасан аялал жуулчлалын үйлчилгээг хамтад нь эрхлэх олон улсын аялал жуулчлалын үйлчилгээ.

12.1.4.дотоодын аялал жуулчлалын үйлчилгээ.

12.2.Тур оператороор бүртгүүлэхдээ дараах мэдээллийг ирүүлнэ:

12.2.1.аялал жуулчлалын мэргэжлийн ажилтны мэдээлэл;

12.2.2.бүтээгдэхүүн, үйлчилгээний талаарх мэдээлэл;

12.2.3.цахим төлбөрийн баримтын систем, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд холбогдсон талаарх мэдээлэл;

12.2.4.хариуцлагын даатгалд хамрагдсан талаарх мэдээлэл.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Гишүүдийн 90 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

30.Төслийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсгийн “нутаг дэвсгэрт” гэсний дараа “энэ хуулийн 13.1-д заасан гадаадын иргэн” гэж нэмж, 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсгийн “12.2.2-т заасан үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөлтэй” гэснийг “12.1.2, 12.1.3-т заасан ангиллаар бүртгүүлсэн” гэж, мөн зүйлийн 13.6 дахь хэсгийн “энэ зүйлд заасны дагуу хил орчмын аялал жуулчлалын үйлчилгээ авч буй гадаадын жуулчны мэдээллийг” гэснийг “хил орчмын аялал жуулчлалын үйлчилгээ авч байгаа жуулчны тоон мэдээллийг” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Гишүүдийн 90 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

31.Төслийн 15 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“15 дугаар зүйл.Даатгал

15.1.Тур оператор, аяллын агент нь үйл ажиллагаандаа алдаа гаргасны

улмаас үйлчлүүлэгчид учруулсан хохирлыг нөхөн төлөх зорилгоор хариуцлагын даатгалд заавал даатгуулна.

15.2.Өндөр уулын авиралт, спорт агнуур, олзворын ан, усны гүнд шумбах, авто спорт, нисдэг тэрэгний аялал зэрэг хүний амь нас, эрүүл мэндэд өндөр эрсдэл бүхий аялалд оролцох жуулчин, жуулчны хөтөч-тайлбарлагч, мэргэшсэн сургагч багш, зааварлагч нь гэнэтийн ослын даатгалд заавал даатгуулсан байна.

15.3.Энэ хуулийн 15.2-т заасан жуулчныг уг даатгалд хамруулах үйл ажиллагааг аялал жуулчлалын байгууллага хариуцан зохион байгуулна.

15.4.Энэ хуулийн 15.1, 15.2-т заасан даатгалын эрсдэл, нөхцөл, үнэлгээ, хураамжийн хэмжээг тогтоох, хяналт тавих журмыг аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Санхүүгийн зохицуулах хороотой хамтран батална. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Гишүүдийн 90 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

32.Төслийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийн “аялж байгаа жуулчинд шаардагдах аюулгүй байдлыг аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага,” гэснийг “жуулчны аюулгүй байдлыг” гэж, мөн зүйлийн 16.5 дахь хэсгийн “тур оператор, аяллын агент, аялал жуулчлалын үйлчилгээний байгууллага, жуулчдад мэдэгдэх” гэснийг “аялал жуулчлалын байгууллага, жуулчинд мэдээлэх бөгөөд өөрийн албан ёсны цахим хуудсанд тухай бүр байршуулах” гэж өөрчилж, 16 дугаар зүйлийн 16.4, 16.7 дахь хэсгийн “бүхий л” гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Гишүүдийн 90 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

33.Төслийн 16 дугаар зүйлийн 16.6, 16.8 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Гишүүдийн 90 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

34.Төслийн 17 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Гишүүдийн 90 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

35.Төслийн 18 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Гишүүдийн 90 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

36.Төслийн 19 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“19 дүгээр зүйл.Аялал жуулчлалын бүс

19.1.Монгол Улс тодорхой газар нутгийг тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх, гадаадын болон дотоодын хөрөнгө оруулалтыг татах, аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг төрөлжүүлэн хөгжүүлэх зорилгоор орон зайн зохистой төлөвлөлтийг бий болгосон аялал жуулчлалын бүстэй байна.

19.2.Аялал жуулчлалын бүсийг дараах байдлаар ангилна:

19.2.1.улсын аялал жуулчлалын бүс;

19.2.2.орон нутгийн аялал жуулчлалын бүс.

19.3. Улсын аялал жуулчлалын бүсийг тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх, аялал жуулчлалын салбарт хөрөнгө оруулалтыг дэмжих, байгаль, түүх, соёлын өв, аялал жуулчлалын нөөцийг хамгаалах зорилгод нийцүүлэн, улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд үндэслэн Засгийн газраас тогтоож, хил заагийг батална.

19.4. Улсын аялал жуулчлалын бүсийн хилийн заагийг тогтооход газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон аялал жуулчлалыг хөгжүүлэх Үндэсний хорооны саналыг авна.

19.5. Улсын аялал жуулчлалын бүсэд аялал жуулчлалын үйл ажиллагаа, газар ашиглалтад холбогдох техникийн зохицуулалт, стандартыг мөрдөх бөгөөд түүнд нийцсэн менежментийн төлөвлөгөөтэй байна.

19.6. Энэ хуулийн 19.5-д заасан менежментийн төлөвлөгөө, бүсийн аялал жуулчлалын маршрутыг аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

19.7. Орон нутгийн аялал жуулчлалын бүсийн хилийн заагийг аймаг, нийслэлийн аялал жуулчлалын асуудал хариуцсан нэгж аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нийцүүлэн боловсруулна.

19.8. Энэ хуулийн 19.7-д заасан хилийн заагийг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал баталж, газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системд болон энэ хуулийн 28.1-д заасан мэдээллийн санд хүргүүлнэ.

19.9. Орон нутгийн аялал жуулчлалын бүс нь менежментийн төлөвлөгөөтэй байна. Орон нутгийн аялал жуулчлалын бүсийн газар зохион байгуулалтын асуудлыг аймаг, нийслэл, сум, дүүргийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлнэ.

19.10. Улсын аялал жуулчлалын бүсэд хамаарах аймаг, нийслэл, сум, дүүргийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд аялал жуулчлалын газрын ашиглалт, хамгаалалтын асуудлыг тусгаж, хэрэгжүүлэхдээ энэ хуулийн 19.5-д заасан техникийн зохицуулалт, стандартыг мөрдөнө.

19.11. Энэ хуулийн 19.9-д заасан орон нутгийн аялал жуулчлалын бүсийн менежментийн төлөвлөгөөг аймаг, нийслэлийн аялал жуулчлалын асуудал хариуцсан нэгж боловсруулж, аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална.

19.12. Улсын аялал жуулчлалын бүсийн менежментийг аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, орон нутгийн аялал жуулчлалын бүсийн менежментийг аймаг, нийслэлийн Засаг дарга хариуцан зохион байгуулна.

19.13. Аялал жуулчлалын бүсийн менежментийг бүхэлд нь, эсхүл тодорхой хэсгийг гэрээний үндсэн дээр хуулийн этгээдээр гүйцэтгүүлж болно.

19.14. Орон нутгийн аялал жуулчлалын бүсийн газар нутгийн хилийн заагийг тогтоохдоо улсын аялал жуулчлалын бүсийн газар нутгийн хилийн заагтай давхцуулж тогтоохыг хориглоно.

19.15. Улсын аялал жуулчлалын бүстэй орон нутгийн аялал жуулчлалын бүс давхацсан тохиолдолд давхацсан хэсгийг холбогдох иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хүчингүй болгоно.

19.16. Улсын болон орон нутгийн аялал жуулчлалын бүсэд үйл ажиллагаа эрхлэх аялал жуулчлалын үйлчилгээний байгууллага, нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал эрхлэгч хоорондын орон зайн төлөвлөлтөд холбогдох техникийн

зохицуулалт, стандартыг заавал дагаж мөрдөнө. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Гишүүдийн 90 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

37.Төслийн 20 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

20 дугаар зүйл. Отоглох цэг

20.1. Улсын аялал жуулчлалын бүс болон улсын тусгай хамгаалалттай газар нутагт аялал жуулчлалын эрэлт, байгаль орчны даацыг үндэслэн байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага отоглох цэг байгуулах байршилыг тогтооно.

20.2. Энэ хуулийн 20.1-д заасан улсын тусгай хамгаалалттай газар нутагт отоглох цэгийг улсын төсвийн, тухайн тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны болон олон улсын төслийн хөрөнгө оруулалтаар байгуулна.

20.3. Энэ хуулийн 20.1-д заасан улсын тусгай хамгаалалттай газарт отоглох цэгийн менежментийг тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа хэрэгжүүлэх бөгөөд менежментийг гэрээний үндсэн дээр хуулийн этгээд, орон нутгийн иргэнээр гүйцэтгүүлж болно.

20.4. Энэ хуулийн 20.1-д заасан улсын аялал жуулчлалын бүс нь улсын тусгай хамгаалалттай газартай давхцаагүй тохиолдолд тухайн аялал жуулчлалын бүс дэх отоглох цэгийн менежментийг гэрээний үндсэн дээр хуулийн этгээд, орон нутгийн иргэнээр гүйцэтгүүлж болно.

20.5. Энэ хуулийн 20.4-т заасан отоглох цэгийн менежментийг гэрээний үндсэн дээр гүйцэтгэх этгээдийг аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн

захиргааны төв байгууллага сонгон шалгаруулна.

20.6. Энэ хуулийн 20.1-д заасан улсын тусгай хамгаалалттай газарт отоглох цэгийн үйлчилгээний хураамж авах, зарцуулахтай холбогдсон харилцааг Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулиар зохицуулна.

20.7. Отоглох цэг нь байнгын, эсхүл түр байж болох бөгөөд стандартын шаардлага хангасан байна.

20.8. Отоглох цэгт олон нийтийн аюулгүй байдлыг хангах харилцааг Цагдаагийн албаны тухай хуулиар зохицуулна.”

Энэ дээр асуулт байна.

20.2. Энэ хуулийн 20.1-д заасан улсын тусгай хамгаалалттай газар нутагт отоглох цэгийг улсын төсвийн, тухайн тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны болон олон улсын төслийн хөрөнгө оруулалтаар байгуулна гэсэн энэ заалтаа тайлбарлах уу? Одоо ямар жишиг явж байгаа юм. Энэ дээр баахан отоглох цэг манай Байгаль орчин, аялал жуулчлалын яам баахан отоглох цэг байгуулах энийг хөрөнгө оруулалтыг шийдээд ийм цэгүүд байгуулаад энэ ажлыг зохион байгуулаад явах юм уу?

Ажлын хэсгийн 5 номерыг нээе.

Т.Мөнх-Од: Асуултад хариулъя.

20.2 буюу энэ жилээс бид нар Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд Зөвшөөрлийн тухай хуулийг дагаж орсон 1 сарын 6-ны нэмэлт, өөрчлөлтөөр Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд оруулж Тусгай хамгаалалттай газар нутгийн хураамжийг бол өөрчилсөн байгаа. Хуучин бол 300 төгрөгөөр явдаг байсан. Одоо бол бид нар БОАЖ-ын сайд тухайн хураамжийг журамлаж, баталж орсон

хөрөнгө оруулалтыг тухайн тусгай хамгаалалтын захиргаа бол зарцуулахаар ийм зохион байгуулалтуудыг хийсэн байгаа. Өөрөөр хэлбэл цаашидаа нэгэнт тусгай хамгаалалтын хураамж нэмэгдэж байгаа тохиолдолд нөгөө талдаа тухайн Тусгай хамгаалалттай газар нутгийн ийн захиргаа бол менежментээ сайн явуулахын хэрээр хураамжаа авах тэр хэмжээгээрээ отоглох цэг болон тодорхой хэмжээний бүтээн байгуулалтыг хийгээд эргээд тэндээсээ орлого олох гэдэг утгыг бид нар оруулж өгч байгаа юм. Олон улсын хувьд бол манай БОАЖЯ-ан дээр тусгай хамгаалалттай газар нутгууд дээр манай KFW-гийн төслүүд хэрэгждэг. Ялангуяа TNCT Тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг 2030 он гэхэд 30 хувь хүртэл нэмэгдүүлэх ийм хэлбэрээр бид нар ажиллаж байгаа.

Тэгэхээр цаашидаа Тусгай хамгаалалттай газар нутаг гэдэг маань бол аялал жуулчлалыг дэмжих чиглэлээр эдийн засгийн эргэлтийг бий болгох энэ нь өөрөө отоглох цэг хэлбэрээр явах, тэрийг нь иргэд одоо жишээлбэл хэтэрхий тухайн газар орон нутагтаа тусгай хамгаалалтад авч байгаа бид нар ашиглах боломжгүй, суурьших боломжгүй, эдийн засгийн эргэлт бий болгох боломжгүй гэдэг ийм утга агуулгууд хөндөгдөж байгаа учраас тухайн отоглох цэгээр дамжуулсан эдийн засгийн эргэлтийг бий болгох энэ менежментийг бид нар оруулж өгч байгаа л гэж ойлгож болно гэсэн үг.

Ц.Цэрэнпунцаг: Ер нь зүгээр анхаараарай. Ингээд л энэ чинь эндээс төсвөөсөө тэгээд л гадаадаас олон улсын янз бүрийн төсөл хөтөлбөрүүд их оруулж ирээд л тэгээд л хийх юм байна шүү ер нь. Тэгэхээр цааши нь энийг бас нэг их юун дээр чуулганы юун дээр, чуулганаар орж ирэхээр бас дахиад гишүүд асуух байх. Ер нь энэ дээр бас бид нар ямар бодлоготой байх юм? Аль болохоор хувийн хэвшилүүдээрээ хийлгэх тэр нэг хураамж аваад тэрүүгээрээ нэг отоглох цэгүүдээ байгуулаад явчих хэмжээний юм цугладаг

юм уу үгүй юү? Тэр нь үндэслэл нотолгоо нь юу байгаа юм, судалгаа нь юу байгаа юм, одоо авч байгаа юм юм уу? Та нар тэрэн дээрээ тоо баримтаа сайн авчраарай. Энэ дээр санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Гишүүдийн 90 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

38.Төслийн Гуравдугаар бүлгийн гарчгийг “АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БҮС” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Гишүүдийн 90 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

39.Төслийн Дөрөвдүгээр бүлгийн гарчгийн “БАЙГУУЛЛАГА, АШГИЙН ТӨЛӨӨ БҮС” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Гишүүдийн 90 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

40.Төслийн 21 дүгээр зүйлийн 21.1.5 дахь заалтын “хуулийн” гэсний дараа “6.6, 21.5,” гэж, 21.2.1 дэх заалтын “боловсруулах” гэсний дараа “болон хэрэгжүүлэх асуудлаар Ерөнхий сайдад зөвлөгөө өгөх, санал гаргах” гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Гишүүдийн 90 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

41.Төслийн 21 дүгээр зүйлийн 21.1.6 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“21.1.6.аялал жуулчлалын дэд бүтцийг хөгжүүлэх

ерөнхий төлөвлөгөөг батлах.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Гишүүдийн 90 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

42.Төслийн 21 дүгээр зүйлийн 21.2.3 дахь заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Гишүүдийн 90 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

43.Төслийн 21 дүгээр зүйлийн 21.3 дахь хэсэг, 21.4 дэх хэсгийг тус тус доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“21.3.Үндэсний хороог Ерөнхий сайд тэргүүлэх бөгөөд байгаль орчин, аялал жуулчлал, төсөв, санхүү, эдийн засаг, тээвэр, эрчим хүч, гадаад харилцаа, хууль зүй, соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас санал болгосон тус бүр нэг, энэ хуулийн 27.1-д заасан нийтийн эрх зүйн хуулийн этгээдээс санал болгосон таван гишүүнээс бүрдэнэ.

21.4.Үндэсний хороо орон тооны бус байх бөгөөд гишүүдийг Ерөнхий сайд томилж, чөлөөлнө.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Гишүүдийн 90 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

44.Төслийн 21 дүгээр зүйлийн 21.2-21.5 дахь хэсгийг 22 дугаар зүйл болгон зүйлийн нэрийг “Аялал жуулчлалыг хөгжүүлэх Үндэсний хорооны бүрэн эрх” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Гишүүдийн 90 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

45.Төслийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“22.1.13.аялал жуулчлалын талаар төрөөс баримтлах бодлого, хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулж, биелэлтэд хяналт тавих.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Гишүүдийн 90 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

46.Төслийн 22 дугаар зүйлийн 22.1.1 дэх заалтын “6.6, 10.3, 11.3-т” гэснийг “10.3, 15.4-т” гэж, 22.1.5 дахь заалтын “жуулчны үйлчилгээний байгууллагын” гэснийг “аялал жуулчлалын үйлчилгээний байгууллага, нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал эрхлэгчийн” гэж, 22.1.7 дахь заалтын “үйлдвэрлэл, үйлчилгээ” гэснийг “үйлдвэрлэлийг хөгжүүлэх” гэж, 22 дугаар зүйлийн 22.1.11 дэх заалтын “бий болгоход дэмжлэг үзүүлэх” гэснийг “хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Гишүүдийн 90 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

47.Төслийн 22 дугаар зүйлийн 22.1.7 дахь заалт, 22.1.9 дэх заалтын “боловсруулах” гэсний дараа “, хэрэгжүүлэх” гэж, 22.1.4 дэх заалтын “аялал жуулчлалын” гэсний дараа “хүний нөөцийг бэлтгэх, мэргэжлийн удирдлагаар хангах” гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Гишүүдийн 90 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

48.Төслийн 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Гишүүдийн 90 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

49.Төслийн 24 дүгээр зүйлийн 24.1.4 дэх заалтын “батлагдсан хөтөлбөрийн дагуу аялал жуулчлалын төлөвлөгөө боловсруулж” гэснийг, 24.1.5 дахь заалтын “эрх хэмжээнийхээ хүрээнд” гэснийг, 24.1.7 дахь заалтын “наадам, бусад” гэснийг тус тус хасаж, 24 дүгээр зүйлийн 24.1.7 дахь заалтын “тухайн жилийн” гэснийг “өмнөх оны” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Гишүүдийн 90 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

50.Төслийн 24 дүгээр зүйлийн 24.1.12 дахь заалтын “харьяалах” гэсний өмнө “шаардлагатай тохиолдолд” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Гишүүдийн 90 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

51.Төслийн 24 дүгээр зүйлийн 24.1.8, 24.1.11 дэх заалт, мөн зүйлийн 24.2 дахь хэсэг болон “Тайлбар” хэсгийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Гишүүдийн 90 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

52.Төслийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“24.1.15.харьяалах нутаг дэвсгэртээ улсын болон олон улсын чанартай авто замын дагуу аялал жуулчлалын үйлчилгээ эрхлэгч иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, жуулчинд үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд хамтран ажиллах;” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Гишүүдийн 90 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

53.Төслийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“24.1.16.аялал жуулчлалыг хөгжүүлэх хэрэгцээ, шаардлагыг харгалзан аймаг, нийслэлд аялал жуулчлалын асуудал хариуцсан нэгж, эсхүл ажилтан ажиллуулах.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Гишүүдийн 90 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

54.Төслийн 25 дугаар зүйлийн 25.1.3, 25.1.4 дэх заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Гишүүдийн 90 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

55.Төслийн 26 дугаар зүйлийн 26.1.8 дахь заалт, мөн зүйлийн 26.2 дахь хэсгийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Гишүүдийн 90 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

56.Төслийн 26 дугаар зүйлийн 26.1.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“26.1.3.харьяалах нутаг дэсвэртээ байгуулах жуулчны үйлчилгээний байгууллагад газар эзэмших зөвшөөрлийг аялал жуулчлалын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын тогтоосон нөөц, даац, тоо, байршилыг баримтлан хууль тогтоомжийн дагуу олгож гэрээ байгуулах;” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Гишүүдийн 90 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

57.Төслийн 26 дугаар зүйлийн 26.1.4 дэх заалтын “аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлэгч иргэний үйл ажиллагааг хөгжүүлэхэд” гэснийг “нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалын үйл ажиллагаанд” гэж, 26.1.7 дахь заалтын “отоглох цэгийн байршил, аяллын маршрутыг тогтоох,” гэснийг “аяллын маршрутын дагуу” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Гишүүдийн 90 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

58.Төслийн 27 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, Тавдугаар бүлэг болгон өөрчлөх.

**“ТАВДУГААР БҮЛЭГ.АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН МЭРГЭЖЛИЙН
ХОЛБОО**

27 дугаар зүйл.Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо

27.1.Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо нь тур оператор, аяллын агент, аялал жуулчлалын үйлчилгээний байгууллага, жуулчны

хөтөч-тайлбарлагч, нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал эрхлэгчийн нэгдэл бүхий, аялал жуулчлалын үйл ажиллагаанд оролцогчдыг сургалт, зөвлөгөө, мэдээлэл, мэргэжлийн арга зүйгээр хангах, аялал жуулчлалын байгууллагын ажилтны баримтлах мэргэжлийн ёс зүйн дүрмийг батлах, боловсронгуй болгох үндсэн чиг үүрэг бүхий ашигийн төлөө бус нийтийн эрх зүйн хуулийн этгээд /цаашид “холбоо” гэх/ байна.

27.2.Холбооны зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбогдсон энэ хуулиар зохицуулаагүй харилцааг холбооны дүрмээр зохицуулна.

27.3.Холбоо нь аялал жуулчлалын салбарын мэргэжилтнүүдийн мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр төрийн, ашигийн төлөө бус хуулийн этгээд болон олон улсын байгууллагатай хамтран ажиллаж болно.

27.4.Холбоо нь тухайн жилийн үйл ажиллагааны тайлангаа дараа оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн дотор аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, аудитлагдсан санхүүгийн тайлангаа харилцагч санхүүгийн байгууллагад, татварын тайлангаа харьяалах татварын албанд хуульд заасан хугацаанд хүргүүлж, олон нийтэд нээлттэй мэдээлнэ. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Гишүүдийн 90 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

59.Төслийн Тавдугаар бүлэгт доор дурдсан агуулгатай 28 дугаар зүйл нэмэх:

“28 дугаар зүйл.Холбооны их хурал

28.1.Холбооны эрх барих дээд байгууллага нь Аялал жуулчлалын мэргэжлийн холбооны их хурал /цаашид “их хурал” гэх/ байна.

28.2.Их хурал нь ээлжит болон ээлжит бус хэлбэртэй байх бөгөөд ээлжит хурлыг жилд нэг удаа хуралдуулна.

28.3.Их хурлын төлөөлөгчдийн олонх оролцоноор хурал хүчин төгөлдөр болно.

28.4.Их хуралд оролцох төлөөлөгчдийг сонгох журмыг холбооны дүрмээр тогтооно.

28.5.Их хурлын төлөөлөгчид нь холбооны гишүүнчлэлтэй аялал жуулчлалын байгууллагын төлөөллөөс бүрдэнэ.

28.3.Их хурал дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

28.3.1.холбооны дүрмийг батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах;

28.3.2.аялал жуулчлалын салбарын ажилтны мэргэжлийн ёс зүйн дүрмийг батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах;

28.3.3.холбооны Удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох, чөлөөлөх.

28.3.4.холбооны Удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны тайланг хэлэлцэх, санал, зөвлөмж өгөх;

28.3.4.хууль болон холбооны дүрмээр тогтоосон бусад асуудал.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Гишүүдийн 90 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

60.Төслийн Тавдугаар бүлэгт доор дурдсан агуулгатай 29 дүгээр зүйл нэмэх:

“29 дүгээр зүйл.Холбооны Удирдах зөвлөл

29.1.Холбооны Удирдах зөвлөл /цаашид “Удирдах зөвлөл” гэх/ нь Их хурлын чөлөөт цагт холбооны үйл ажиллагааг зохион байгуулах чиг үүрэг бүхий хамтын удирдлагын байгууллага байна.

29.2.Удирдах зөвлөл нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

29.2.1.холбооны гүйцэтгэх удирдлагыг томилох, чөлөөлөх;

29.2.2.холбооны дүрэм, журмын хэрэгжилт, жилийн ажлын төлөвлөгөө, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавих;

29.2.3.холбооны их хурлыг зарлан хуралдуулах;

29.2.4.холбооны жилийн төсөв, ажлын төлөвлөгөөг батлах, үйл ажиллагааны тайланг хэлэлцэх;

29.2.5.хууль болон холбооны дүрэмд заасан бусад бүрэн эрх.

29.3.Удирдах зөвлөл 15 гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд тур оператораас 5, аяллын агент, зочид буудал, жуулчны бааз, агаарын тээврийн үйлчилгээ үзүүлэгч компани болон аялал жуулчлалын үйлчилгээний бусад байгууллагаас тус бүр 2 төлөөллөөс бүрдэнэ.

29.4.Удирдах зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа 3 жил байх бөгөөд улируулан сонгохгүй.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Гишүүдийн 90 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

61.Төслийн Тавдугаар бүлэгт доор дурдсан агуулгатай 30 дугаар зүйл нэмэх:

“30 дугаар зүйл.Холбооны гүйцэтгэх удирдлага

30.1.Холбооны гүйцэтгэх удирдлагын бүрэн эрхийн хугацаа гурван жил байх бөгөөд улируулан сонгохгүй.

30.2.Холбооны гүйцэтгэх удирдлага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

30.2.1.холбоог гадаад, дотоод харилцаанд төлөөлөх;

30.2.2.холбооны үйл ажиллагааг удирдан явуулах;

30.2.3.холбооны төсөв, төлөвлөгөөг боловсруулах, батлуулах;

30.2.4.санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг хуульд заасан журмын дагуу гаргах, эрх бүхий байгууллагаар хэлэлцүүлэх, холбогдох байгууллагад хүргүүлэх;

30.2.5.Удирдах зөвлөлөөс олгосон бүрэн эрхийн хүрээнд холбоог төлөөлөн гэрээ, хэлцэл хийх;

30.2.6.хууль болон холбооны дүрэмд заасан бусад бүрэн эрх.

30.3.Холбооны гүйцэтгэх удирдлага нь Аялал жуулчлалыг хөгжүүлэх Үндэсний хорооны бүрэлдэхүүнд ажиллана.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Гишүүдийн 90 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

62.Төслийн 28 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, Зургаадугаар бүлэгт тусгах:

“28 дугаар зүйл.Аялал жуулчлалын мэдээллийн сан

28.1.Аялал жуулчлалын салбарын судалгаа, шинжилгээ, статистик мэдээллийн нэгдсэн сан /цаашид “Аялал жуулчлалын мэдээллийн сан” гэх/-г аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага цахим хэлбэрээр бүрдүүлнэ.

28.2.Аялал жуулчлалын мэдээллийн сан нь дараах мэдээллээс бүрдэнэ:

28.2.1.хууль тогтоомжийн болон салбарын хүний нөөцийн мэдээлэл;

28.2.2.дотоодын болон олон улсын жуулчны тоон мэдээлэл;

28.2.3.аялал жуулчлалын байгууллагын бүртгэл, мэдээлэл;

28.2.4.улсын, орон нутгийн, хил орчмын аялал жуулчлалын бүс, маршрутын мэдээлэл;

28.2.5.олон улсын, улсын болон орон нутгийн чанартай авто зам дагуух үйлчилгээний байгууламжийн мэдээлэл;

28.2.6.энэ хуулийн 20 дугаар зүйлд заасан отоглох цэгийн мэдээлэл;

28.2.7.энэ хуулийн 16.5-д заасан жуулчдад учирч болзошгүй аюул, халдварт өвчин, тахал болон зорчиход аюултай газар, байршлын талаарх мэдээлэл.

28.3.Аялал жуулчлалын мэдээллийн сан нь нийтэд нээлттэй байна.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Гишүүдийн 90 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

60.Төслийн Тавдугаар бүлгийн гарчгийг “Зургаадугаар бүлэг. Бусад зүйл” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Гишүүдийн 90 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

61.Төслийн 29 дүгээр зүйлийн 29.4, 29.5 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Гишүүдийн 90 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

62.Төслийн 29.2-29.6 дахь заалтыг 30 дугаар зүйл болгон өөрчилж, зүйлийн гарчгийг “30 дугаар зүйл.Аялал жуулчлалын үйл ажиллагаанд тавих төрийн хяналт” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Гишүүдийн 90 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

63.Төслийн 30 дугаар зүйлийн 30.1.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

“30.1.1.аялал жуулчлалын хууль тогтоомжийг зөрчсөн тухай өргөдөл, гомдлыг эрх бүхий байгууллагад гаргаж, шийдвэрлүүлэх;” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Гишүүдийн 90 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

64.Төслийн 32 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“32 дугаар зүйл.Шилжилтийн үеийн зохицуулалт

32.1.Энэ хуулийн 27 дугаар зүйлд заасан нийтийн эрх зүйн хуулийн этгээдийг үүсгэн байгуулах хурлыг аялал жуулчлалын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан журмын дагуу аялал жуулчлалын асуудал эрхэлсэн

төрийн захиргааны төв байгууллага энэ хууль батлагдсан өдрөөс хойш 90 хоногийн дотор зохион байгуулна.

32.2.Энэ хууль батлагдсан өдрөөс өмнө байгуулагдан аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа явуулж байгаа тур оператор, аяллын агент, аялал жуулчлалын үйлчилгээний байгууллага хамтран энэ хуулийн 27 дугаар зүйлд заасан нийтийн эрх зүйн хуулийн этгээдийг үүсгэн байгуулна.

32.3.Аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 32.1-д заасан хуралд оролцох байгууллагыг нээлттэй бүртгэх ба тур оператор, аяллын агент, аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагын зохистой харьцааг хангаж хурлыг зохион байгуулна.

32.4.Энэ хуулийн 6.5-д заасны дагуу тур оператор, аяллын агент нь 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор энэ хуулийн 27.1-д заасан нийтийн эрх зүйн хуулийн этгээдэд бүртгүүлнэ. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Гишүүдийн 90 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

65.Төслийн 33 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Гишүүдийн 90 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

66.Төслийн “хөтөч” гэснийг “хөтөч-тайлбарлагч” гэж тохиолдол бүрд агуулгад нийцүүлэн өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Гишүүдийн 90 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

67.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн нэр томьёог жигдлэх, зүйл, хэсэг, заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх, бүтэц, найруулга, хууль зүйн техникийн засварыг хийх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Гишүүдийн 90 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Найруулгын санал:

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “үндэсний онцлог бүхий байгаль” гэснийг “байгаль, үндэсний онцлог бүхий” гэж, 7 дугаар зүйлийн 7.1.4 дэх заалтын “худалдах,” гэснийг “худалдан” гэж, 10 дугаар зүйлийн 10.2.1 дэх заалтын “энгэрийн тэмдэг, үнэмлэхийг” гэснийг “үнэмлэх, энгэрийн тэмдэг” гэж, 16 дугаар зүйлийн 16.5 хэсгийн “хариуцсан” гэснийг “эрхэлсэн” гэж, 21 дүгээр зүйлийн 21.1.1 дэх заалтын, мөн 23 дугаар зүйлийн 23.1.1 дэх заалтын “төрийн” гэснийг “төрөөс баримтлах” гэж, 21.1.5 дахь заалтын “харилцааг” гэснийг “харьцааг” гэж, “23 дугаар зүйлийн 23.1.2 дахь заалтын “газар нутгийнхаа” гэснийг “нутаг дэвсгэрийнхээ” гэж, 24 дүгээр зүйлийн 24.1.1 дэх заалтын “бодлого, зорилтот хөтөлбөрийн” гэснийг “бодлогын” гэж, 24.1.14 дэх заалтын “жуулчин, аялагчийн” гэснийг “жуулчны” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Гишүүдийн 90 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

2.Төслийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийн “эрх,” гэснийг, 15 дугаар зүйлийн 15.5 дахь хэсгийн “аялагч болон” гэснийг, 16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсгийн “, аялагч” гэснийг, 22 дугаар

зүйлийн 22.1.4 дэх заалтын “ажлыг хөгжүүлэх” гэснийг, 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсгийн “тухай” гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Гишүүдийн 90 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

3.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.6 дахь заалтын “зохион байгуулах” гэсний өмнө “аялал” гэж, 7 дугаар зүйлийн 7.1.2 дахь заалтын “борлуулах” гэсний өмнө “худалдан” гэж, 21 дүгээр зүйлийн 21.2.4 дэх заалтын “аялал жуулчлалын” гэсний дараа “асуудлаар” гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Гишүүдийн 90 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол:

1.Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн нэрийн “НЭМЭЛТ,” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Гишүүдийн 90 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн “374 дүгээр зүйлийн” гэсний дараа “374.1,” гэж, мөн зүйлийн “373.4 дэх хэсгийн “аялал жуулчлал” гэсний дараа “зохион байгуулагч” гэж, “372 дугаар зүйлийн 372.3 дахь хэсэг,” гэсний өмнө “372 дугаар зүйлийн 372.2 дахь хэсгийн “Аялал зохион байгуулагч” гэснийг “Тур оператор, аяллын агент” гэж,” гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Гишүүдийн 90 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол:

1.Төслийг хууль санаачлагчид нь буцаах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Гишүүдийн 90 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол:

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын “21 дүгээр зүйлийн 21.1.15 дахь заалт:” гэснийг “22 дугаар зүйлийн 22.5.12 дахь заалт:” гэж, мөн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 22 дугаар зүйлийн 22.9 дэх хэсгийн дугаарыг “22 дугаар зүйлийн 22.5.13 дахь заалт” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Гишүүдийн 90 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийн “22.9-д” гэснийг “22.5.13-д” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Гишүүдийн 90 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол:

1.Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөх.

“1 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хуулийн 10.14 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“10.14.Аялал жуулчлалын тухай хууль зөрчих

1.Тур оператор, эсхүл аяллын агентын үйл ажиллагааг эрхлэхдээ хуульд заасан бүртгэл хийлгээгүй бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2.Аялал жуулчлалын үйлчилгээний байгууллага нь үйлчилгээний стандарт, техникийн зохицуулалт, зэрэглэлд тавигдах шаардлагыг зөрчиж үйл ажиллагаа явуулсан бол хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Гишүүдийн 90 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол:

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 15 дугаар зүйлийн 15.5¹ дэх хэсгийн “нэг хоногоос” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Гишүүдийн 90 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 15 дугаар зүйлийн 15.5¹ дэх хэсгийн дугаарыг “15 дугаар зүйлийн 15.6

дахь хэсэг” болгож, мөн зүйлийн 2 дахь заалт буюу 15 дугаар зүйлийн 15.16, 15.17, 15.18 дахь хэсгийн дугаарыг “15 дугаар зүйлийн 15.17, 15.18, 15.19 дэх хэсэг” болгож, мөн зүйлийн 2 дахь заалтын 15.16 дахь хэсгийн, 15.17 дахь хэсгийн, 15.18 дахь хэсгийн “15.5¹ гэснийг “15.6” гэж, 15.18 дахь хэсгийн “15.16.4-т” гэснийг “15.17.4-т” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Гишүүдийн 90 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

3.Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.9 дэх хэсгийн “15.5” гэсний дараа “, 15.6” гэж нэмсүгэй.” Санал гаргасан ажлын хэсэг.

Энэ хууль дээр гурав дахь санал.

Санал хураалт.

Гишүүдийн 90 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

4.Төслийн 3 дугаар зүйлийн “эрхэлдэг” гэсний өмнө “хуулийн этгээд” гэж, “өөрчилсүгэй.” гэсний өмнө “, 15 дугаар зүйлийн 15.7 дахь хэсгийн “15.6-д” гэснийг “15.7, 15.5.18-д” гэж, мөн зүйлийн 15.6, 15.7, 15.8, 15.9, 15.10, 15.11, 15.12, 15.13, 15.14, 15.15 дахь хэсгийн дугаарыг “15.7, 15.8, 15.9, 15.10, 15.11, 15.12, 15.13, 15.14, 15.15, 15.16” гэж тус тус” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Гишүүдийн 90 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

5.Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 1 дэх заалт нэмэх:

“1/13 дугаар зүйлийн 13.5.21, 13.5.22, 13.5.23 дахь заалт:

13.5.21.орон нутгийн агаарын тээврийн үйлчилгээ;

13.5.22.олон улс, орон нутгийн нисэх буудлын үйлчилгээ;

13.5.23.иргэний агаарын хөлгийн түрээсийн үйлчилгээ.” Санал гаргасан ажлын хэсэг.

Жавхлан гишүүн саналаа хэлье.

Б.Жавхлан: Цэрэнпунцаг даргад баярлалаа.

Энэ асуудал дахиад 2 дахь удаагаа яригдаж байна аа. Өмнө нь Байнгын хороон дээр бас 1 удаа яригдаад Засгийн газраас буюу татварын асуудал хариуцсан чиглэлийн яам болох Сангийн яамнаас бид энэ дээр тодорхой санал ажлын хэсэгт ирүүлсэн байгаа. Тэр санал дээр маш тодорхой заасан байгаа. Аялал жуулчлалын жил болж байгаатай холбогдуулж мөн энэ хууль өргөн баригдсан. Засгийн газраас өргөн баригдсан. Засгийн газраас өргөн баригдсан хувилбар дээр энэ заалтууд бол байхгүй байгаа.

Ажлын хэсгийн гишүүдээс мөн энэ саналыг боловсруулж оруулж ирж байгаа агуулга зорилгыг нь бол ойлгож байна л даа. Бид аялал жуулчлалын зээлүүдийг зарлачхаад дотоодын нислэгүүдийнхээ үнэ өртгийг бууруулах ийм мэдээж шаардлагууд байгаа. Гэхдээ энэ арга зам нь болохгүй байна. Тодорхой үр дүн гарахгүй ээ. Бид НӨАТ-ын татварын 10 хувийг чөлөөлснөөр 10 хувиар үнэ буухгүй. Тэр агаарын тээврийн дотоод нислэг хийж байгаа оператор компаниудын ярьж байгаагаар бол 2-оос максимум 3 хувь буух юм шиг байгаа юм. Ийм хувь буулгахын төлөө нэмэгдсэн өртгийн албан татвар гээд татварынхаа том тогтолцоог ингэж эвдэх нь өөрөө их том хохиролтой юм. Үр дүн гарахгүй маш жижиг тэр өөрчлөлтийн төлөө маш том тогтолцооны эрсдэлд орох нь ээ гэсэн ийм

товчхондоо утга агуулгатай ийм санал хүргүүлсэн байгаа. Гэхдээ Засгийн газар мөн одоо энэн дээр бас зүгээр байхгүй байгаа. Дотоодын нислэгийн үнэ тариф өртгийг нь бууруулахаар ЗГХЭГ дээрээс нэлээн судалгаа хийгдээд ялангуяа салбарын яг тэр дотоодын нислэг тойрсон захиргааны шинжтэй ийм арга хэмжээнүүдийг авснаар үнийг нь бууруулж болох юм гэсэн ийм үндэслэлтэй ийм судалгаа гаргаж Амарбаясгалан сайд маш тодорхой энэ дээр болбол ажиллаж хариулт хэлж байгаа. Ганхуяг гишүүн ээ.

Тийм учраас энэ дээр бас тодорхой илүү үр дүн гарах тал руу нь хэдүүлээ нийлж хамтарч үр дүн гаргах нь зүйтэй байх Засгийн газар дээр би дахиад хэлье. Хэрэг эрхлэх дээрээс энэ асуудал дээр ярьж байгаа. Бямбацогт сайдад бас энэ талаар Амарбаясгалан сайд та 2 бас ярилцсан байх гэж найдаж байна.

Тийм учраас энэ заалтуудыг Ганхуяг гишүүнд ахлаад ажлын хэсгийнхэн маань энийг буцааж саналаа татаж аваач ээ гэсэн санал Засгийн газраас өгч байна гэсэн үг.

Бямбацогт сайд кабинетын зарчмаар ажиллаж байгаа байлгүй дээ.

Ц.Цэрэнпунцаг: Бямбацогт гишүүн үг хэлье гэж байна. Бямбацогт гишүүний микрофоныг, дараа нь Адъяаа гишүүн үг хэлэх юм байна.

С.Бямбацогт: Жавхлан сайдын бас ярьж байгаа зүйлийг ойлгож байгаа Засгийн газраас өргөн барихдаа энэ агаарын тээврийн нэмэгдсэн өртгийн албан татварын асуудлыг хөндөөгүй орж ирсэн. Ажлын хэсэг дээр хөндсөн ажлын хэсэг хөндөөд оруулж ирж байгаа. Өөрөөр хэлэх юм болбол Засгийн газрын өргөн барьснаас нэмэлтээр орж ирж байгаа асуудал. Өнгөрсөн 2022 оны 11 сард болсон Монгол Улсын Их Хурал төсөв батлахдаа Монгол Улсын Засгийн газарт энэ дотоодын нислэгийн тарифыг бууруулах ийм бас үүргийг өгсөн.

Төсөв дагасан тогтоолоор. Өөрөөр хэлэх юм бол Төсвийн тухай хуулийг дагасан тогтоол бол хуулийн адил хүчин төгөлдөр. Энийг бид нар биелүүлэх үүрэгтэй Засгийн газар. Засгийн газар хуулийг биелүүлэх хуулийн хэрэгжилтийг зохион байгуулж, биелүүлэх үүрэгтэй төрийн бодлого тодорхойлдог байгууллага Улсын Их Хурал.

Тийм учраас ажлын хэсэг бас тэр агуулгаараа орж ирсэн байх гэж бодож байгаа. Мөн Засгийн газраас бас надад, Зам, тээврийн хөгжлийн сайдад бас энэ орон нутгийн нислэгийг сэргээ, дотоодын нислэгийн үнэ тарифыг бууруул гэсэн үүргийг удаа дараа өгчих байгаа. Тэгээд орон нутгийн нислэгийг сэргээхийн тулд олон арга хэмжээ авах ёстой. Үүний нэг авч байгаа нэг арга хэмжээ бол энэ дотоодын нислэгийн үнэ тарифыг бууруулах асуудал. Энэ нислэгийн НӨАТ-ыг чөлөөлөх. Яагаад вэ гэхээр өнөөдөр үндсэндээ бол хэрвээ огт байхгүй асуудлыг чөлөөлөх гэж байгаа бас нэг өөр асуудал л даа.

Өнөөдөр гадаад нислэг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөгдөж байгаа.

Дээрээс олон улсад гадаад нислэгтэй. Дээрээс нь төмөр замын тээвэр тийм үү төмөр замын зорчигч тээвэр бүгдээрээ байнга нэмэгдсэн өртгийн албан татвар чөлөөлөгдөж байгаа Замын-Үүд рүү, Дархан руу, Эрдэнэт рүү, Сэлэнгэ рүү. Энэ зорчигчдын НӨАТ төлдөггүй.

Дээрээс нь Улаанбаатар хотын нийтийн тээвэр, хот хоорондын зорчигч тээвэр аймаг хоорондын. Бүгд нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөгдөж байгаа. Тэр бүү хэл Улаанбаатар хотын нийтийн тээвэр дээр 200 тэрбум төгрөгийн татаасыг улсаас төрөөс өгч байгаа. Ийм байдлаар үндсэндээ нийтийн тээврийг дэмжиж байгаа. Агаарын тээвэр, нийтийн тээврийн нэг л хэсэг.

Тийм болохоор энэ агуулгаараа бас энэ орон нутгийн агаарын тээврийн үйлчилгээний нэмэгдсэн өртгийн албан татварыг чөлөөлөх ажлын хэсгийн саналыг дэмжиж байгаа юм аа.

Хоёрдугаарт нь олон улс, орон нутгийн нисэх буудлын үйлчилгээ.

Өнөөдөр үндсэндээ нисэх буудлын тийз бид нар Сүүл рүү явахад 2 сая 500 байсан бол сая хүртлээ хямдарч байгаа. Дахиад хямдрах бололцоо байгаа. Яагаад гэвэл нисэх буудлын үйлчилгээн дээр үндсэндээ гадаад явж байгаа иргэд 70 долларын нисэх буудлын үйлчилгээ такс төлж байгаа юм.

Нисэх буудлын үйлчилгээний 70 доллар чинь үндсэндээ 200 бараг 50000 төгрөг гэсэн үг.

Хэрвээ нисэх буудлын үйлчилгээг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлчих юм бол тодорхой хэмжээгээр бас энэ гадаад нислэгийн билетийн үнэ буурна.

Дээрээс нь иргэний агаарын хөлгийн түрээсийн үйлчилгээ гэж байгаа юм. Яах аргагүй өнөөдөр бид нар Монголчууд маань онгоцыг бүтнээр нь худалдаад авчих мөнгө алга. Онгоц ихэнх нь түрээсэлж байгаа дандаа түрээс. Тийм болохоор тэр түрээсэлж байгаа юун дээр нь НӨАТ аваад байхаар дахиад л бас дарамт болоод байгаа юм л даа.

Тийм болохоор бид нар агаарын тээврийг либералчлаад гадааддаа бол бас харьцангуй амжилтад хүрч байна. Дотоод нислэгээ сэргээмээр байна. Хуучин 11 аймаг руу онгоц нисдэг байсан бол одоо хоёрхон аймаг руу тогтмол нисэж байна.

Дээрээс нь Увс, Завхан гээд ганц нэгхэн аймаг руу юу гэдэг чартер нислэг өндөр үнэтэй нисэж байна. Тийм болохоор бид нар Монголд аялах зочлох жил гээд 2023, 2024, 2025 он гээд

зарлачихсан. Гаднын жуулчид ирээд Улаанбаатарт замын түгжрэлд нь түгжирч түгжирч байгаад Увс руу явах онгоц байхгүй, Завхан руу онгоц байхгүй, Хөвсгөл рүү онгоц байхгүй, Дорнод руу онгоц байхгүй.

Явах гэсэн фурганоор явна. Фурганоор кондишн байхгүй гээд л. Ингээд л ийм байдалтайгаар үндсэндээ Монголд зочил гэж хүмүүсийг урьчхаад ирэхээр нь тэгээд орон нутагтаа нислэг байхгүй ийм сууж байх нь Монгол Улсын бас нүүр царай жаахан онцгүй л байх л даа.

Дээрээс нь Засгийн газрын бас бодлого байгаа. Орон нутгийн иргэдийг дэмжих төвлөрлийг сааруулах. Энэ бодлогын хүрээнд бид нар орон нутагт амьдарч байгаа иргэдийн ипотекийн зээлийг 6 хувь, Улаанбаатарт 6 хувь байсан бол орон нутагт 3 хувь, банкны арилжааны зээлийг 1 хувь, бүр ингээд өшөө дээрээс нь орон нутагт амьдрах юм бол цалингийн нэмэгдэл өгнө гээд ийм байдлаар Засгийн газар орон нутагт амьдарч байгаа иргэдээ дэмжиж байгаа.

Тийм болохоор л бид нар бас орон нутгийн нислэгийг сэргээхэд бас тодорхой хэмжээгээр.

Ц.Цэрэнпунцаг: Адьшаа гишүүн асуултаа асууя.

Ш.Адьшаа: Энэ аялал жуулчлалын ажлын хэсгийн гишүүн л дээ би. Тэгэхдээ энэ нэмэгдсэн өртгийн албан татвараас энэ 1 хувь компанид зориулсан ийм хувь компанийн татвартай холбоотой асуудлыг нэг хуульд оруулж өгдөг ийм асуудал байж болохгүй ээ. Хууль тогтоомжийн тухай хууль гэж байгаа шүү дээ. Тэр Хууль тогтоомжийн тухай хууль чинь төсөвтэй, татвартай холбоотой асуудлыг энэ асуудлыг хариуцсан Засгийн газрын гишүүн Сангийн яамны зөвшөөрлийг авч байж оруулах ёстой байхгүй юу. Сангийн сайд нь ингээд энэ болохгүй ээ энэ хууль бус юм

болж байна гэдгийг ингэж яриад байх чинь. Дээр нь бол энэ асуудлыг байж байгаарай Бямбацогт оо чи би үгээ хэлчихье.

Тэгээд энэ асуудлыг яасан юм? Чи дуугүй байж бай. Тэгээд энэ дээр ямар асуудал болж байсан юм гэхээр Төсвийн тухай хууль батлахад тэгээд энэ асуудлыг ярилцаад зарчмын зөрүүтэй санал оруулаад төсвийн хууль батлахад энэ дэмжигдэхгүй байсан шүү дээ Улсын Их Хурал дээр. Тэгээд Төсвийн тухай хуулиар оруулж ир л дээ. Нэг хууль батлахаар нэг компанид зориулсан ийм зарчим хийгээд тэрнийгээ хувь компанийн өмнөөс Засгийн газрын гишүүн нь лобби хийчхээд тэр ард түмнийг хохироож байна гэдэг ийм бүдүүлэг ёс зүйгүй асуудал гаргахаа Бямбацогт чи цаашид болиорой.

Энэ асуудал чинь ерөөсөө 1 компанийн төлөө биш шүү дээ. Нийт Монгол Улсын эрх ашгийн төлөө явах ёстой. Тэгээд л Ховдын ард түмнийг ингэж байна гэдэг ийм юм яривал наад чинь андуурал шүү. Өнөөдөр энэ Засгийн газрын гишүүд зарчимтай бай, хуулиа биелүүл ээ. Хууль тогтоомжийн тухай хууль гэж өнөөдөр Улсын Их Хурлын удирдлагаас маш их шаардлага тавьдаг шүү дээ. Тэгээд ийм л асуудал байгаа юм. Тэрнээс биш би өнөөдөр нэг хүмүүст хайртай байна, хайргүй байна гэдэг тухай яримааргүй байна.

Ц.Цэрэнпунцаг: Ганибал гишүүн асуулт асууя.

Н.Ганибал: Байж бай би нэг асуултаа асуугаадахъя. Ер нь бид нар нэг энэ хэд хэдэн юмыг засаад байна л даа. Сая аялал жуулчлалын анх оруулж ирсэн хууль дээр нэлээн засварууд орж ирж байна шүү дээ. Хамгийн гол асуудлууд энэ нөгөө сан байгуулдаг, бид нар өмнө байгуулагдсан сангуудаа яах вэ гэдэг асуудал яригдаад сая сан орж ирээд. Энийг засаж залруулж байна. Яг энэнтэй адилхан энэ ямар нэгэн салбарын суурь

хууль дээр ямар нэгэн энэ татварын асуудлуудыг, сангийн асуудлуудыг, энэ НӨАТ-ын асуудлуудыг оруулж ирэх нь энэ угаасаа бүгдийг нь хуулиар хорих ёстой л доо энэ чинь. Угаасаа энэ иргэний нисэхийн өөрийнх нь үндсэн хууль гэж бас байгаа биз. Одоо хэрэглэдэг хууль тэр. Иргэний нисэхийн тухай хууль гэж байгаа байх. Энэ хууль дээрээ л энэ асуудлууд нь яригдах ёстой. Тэрнээс зөвхөн аялал жуулчлалын том хууль ярьж байснаа тэнд тээврийн зохицуулалт оруулж ирж байгаа нь өөрөө буруу байхгүй юу зарчмын хувьд. Ер нь яагаад энэ орон нутгийн дотоодын нислэгүүд үнэтэй байгаа талаар ер нь энэ салбарын сайдаас асуучихъя. Яг шалтгаан нь юу байгаа юм? Энэ өнөөдөр яагаад ажлын хэсгээс асууя. Яагаад үнэтэй байгаа талаар та бүхэн бас энэ дээр судалгаа хийсэн үү? Тэгээд яг энэ заавал НӨАТ-ын тухай хуульд орох ёстой асуудлыг шийдэгдээд дагалдаад явах асуудлууд маань энэ салбарын үндсэн энэ том хуулиуд дээр орж ирээд асуудлууд үүсгээд байгаа энийг л бид нар эргэж ер нь аль ч хууль дээрээ гаргаж болохгүй гэсэн саналтай байгаа юм. Тэгээд тодруулаад асуух асуулт түрүүнд хариулчихъя.

Ц.Цэрэнпунцаг: Бямбацогт сайд санал хэлсэн. Адьшаа гишүүн бас санал гээд хэлчихсэн тэ.

Ганибал гишүүн сая нэг асуулт асуусан. Ажлын хэсэг дараа нь хариулчих уу? Одоо хариулчих. Тодорхой асуулт байна, товчхон.

Ганхуяг гишүүний микрофоныг нээе битгий дараарай.

Х.Ганхуяг: Ганибал гишүүний асуултад хариулъя.

Ер нь аялал жуулчлалыг хөгжүүлнэ гэдэг ерөөсөө л шууд дэд бүтэцтэй холбогддог юм байна лээ. Манайхаас бусад оронд аялал жуулчлалын асуудлыг бүүр Шадар сайд, Дэд бүтцийн сайдын хэмжээнд тэр асуудлыг хариуцах

хэмжээнд явдаг. Тийм ч учраас энэ аялал жуулчлалын дэд бүтцийн ерөнхий төлөвлөгөө гэж энэнд орж ирж байгаа юм. Бид нар хэчнээн хэмжээний жуулчин даатгаж байгаа юм. Тэгээд ерөнхий төлөвлөгөө гаргалаа. Хаана онгоцны буудал хэрэгтэй юм. Хаана ямар зам хэрэгтэй юм энийгээ ерөнхий төлөвлөгөөндөө бусад салбарын сайдууддаа байлцуулж байгаад ерөнхий төлөвлөгөөгөө батлаад тэгээд тэрийгээ ингээд шат шаттайгаар хийгээд явъя л гэдэг ийм өөрчлөлт орж байгаа юм.

Дэд бүтэц гэдэг маань манайх шиг оронд тэр тусмаа манайх шиг ийм өргөн уудам оронд байна шүү дээ ихэнх нь дотоодын нислэгээр явахгүй л бол машины стандарт нь ний нуугүй хэлэхэд фурганоор л явж байгаа байхгүй юу. Баян-Өлгий рүү явна гэхээрээ тэгээд яах юм. 2, 3 хонож очно шүү дээ. Энэ онгоцоор нисэхээр чинь 1800000 төгрөг байна шүү дээ. Тэгээд яг энэ билетийн үнийн судалгааг хийгээд үзэхэд яах вэ энэ НӨАТ-ын асуудал бол энэ жижигхэн хэсэг нь юм.

Тэгээд яагаад энэ асуудлыг НӨАТ-тай холбоотойгоор Засгийн газраас бол санал ирсэн.

Зочид буудлын НӨАТ-тай холбоотой хэсгийг нь бид нар татчихсан байгаа. Яагаад энэ хэсгийг үлдээсэн бэ гэхээр өнгөрсөн 7 хоногт Засгийн газраас мэдээлэл хийсэн шүү дээ. ЗГХЭГ-ын дарга дотоодын нислэгийн тийзгийг 50 хувь бууруулна гээд. Бид яаж бууруулах гээд байгаа юм. Тэр 50 хувьд нь энэ асуудал орсон юм уу ороогүй юм уу гэдгийг мэдмээр байгаа байхгүй юу.

Тийм учраас энийг үлдээгээд өнөөдөр хэлэлцэж байгаа юм. Тэрнээс биш бид нар дотоодын нислэгийн тийзгийн үнээ бууруулахгүй л манайд аялал жуулчлал хөгжүүлэхэд асар хүнд шүү. 1800000 төгрөг гэдэг чинь Сөүл рүү ниссэнтэй адилхан үнэтэй болчихлоо шүү дээ. Тэгээд яах юм. Баян-Өлгий рүү нисэхэд 1800000 төгрөг байна. Тэгээд

тийм болохоор бид нар энэ дотоодын нислэгийн тоог ч нэмэгдүүлэх хэрэгтэй, онгоц ч нэмэх хэрэгтэй. Бид нар тийзний үнийг ч бууруулах ёстой юм. Тэгээд тийм болохоор би ингээд 2 сайд дээр яриулж байгаад цөмөөрөө гишүүдийнхээ бүрэн эрхээ эдлээд саналаа хураагаад явах нь зөв болов уу гэж харж байгаа юм.

Тэгээд энэ сайд нарын ярьсан юмнуудыг бүгдийг нь протоколдоод авчихмаар байна тийм ээ.

Ц.Цэрэнпунцаг: Жавхлан сайд нэг тайлбар өгчих үү?

Ганибал гишүүн тодруулж асууя гэнэ. Ганибал гишүүн тодруулж асууя. 1 минут өгье.

Н.Ганибал: Би бас нэмээд энэ Сангийн сайдаас бас энэ асуудлыг тодруулж асуумаар байна.

Дээрээс нь ер нь зүгээр энэ шалтгааныг зөвхөн нэмүү өртөг НӨАТ-тай холбож бүх асуудлыг тайлбарлахаараа л өөрөө буруу болчихоод байгаа байхгүй юу.

Дээрээс нь саяын энэ суурь хууль дээр яагаад нэмүү өртгийн асуудлыг оруулж ирээд байгаа нь бас буруу болоод байгаа юм л гэж байгаа юм. Ер нь өнөөдөр баруун аймаг руу онгоц нисэх шалтгаан үнэтэй байгаад байгаа шалтгаанууд нь тодорхой точный судалгаа байхгүй байгаад байна шүү дээ. Бензин үнэтэй байгаа тэр юм уу, том онгоцнууд нисээд, зарим суудал нь хоосон яваад асуудал нь үүсээд байгаа юм уу? Тийм ээ.

Энэ үйл үйлчилгээнүүдийнх нь төлбөр төлөөснүүд нь үнэтэй байгаад байгаа юм уу. Энэ монопол болоод ингээд байгаа юм уу, өрсөлдөөн байхгүй болоод байгаа юм уу, онгоцоо жижгэрүүлж болохгүй юм уу? Тэгээд ингээд зардлуудыг нь багасгаж болохгүй юм уу гээд энэ л асуудлыг тал талаас нь л асуугаад байгаа юм л даа.

Ц.Цэрэнпунцаг: Энхтүвшин гишүүн үг хэлье. Энхтүвшин гишүүн үгээ хэлье.

Т.Энхтүвшин: Баярлалаа. Би энэ НӨАТ-тай холбоотой асуудлыг чөлөөлөх нь зөв өө гэдэг дээр дэмжиж байгаа. Өнөөдөр бид нарын авч байгаа цалин ямар байгаа билээ, олж байгаа орлого ямар байгаа билээ. Тэгэхээр юу гэдэг юм бид нар энэ 800000 цаасны цалин аваад Ховдоос ч гэдэг юм уу, Баян-Өлгийгөөс ч гэдэг юм уу нэг сарынхаа цалингаар л нэг талдаа нисээд Улаанбаатар хотод ирж байна шүү дээ.

Тийм учраас юу гэдэг юм үнийг нь буулгаж чаддаггүй байлаа гэхэд ядаж юу гэдэг юм тэр НӨАТ-аас нь чөлөөлөөд явах нь зүйтэй л гэж би бодож байгаа. Баян-Өлгийгөөс ч гэдэг юм уу энэ Улаанбаатар хотод оюутан болоод ирсэн хүүхэд зуныхаа амралтаар юу гэдэг юм сургуулийн амралтаар нутаг руугаа явж чаддаггүй л байсан юм шүү дээ. Одоо ч тийм байж байгаа. Онгоцны зардал өндөр байдаг. Тэгээд эндээ юу гэдэг юм нэг жилийнхээ сургалтыг дуусгачхаад явдаг. Тэгэхээр бид нар энэ НӨАТ-аас нь чөлөөлөөд энэ онгоцны дотоодын нислэгийг ер нь багасгах хэрэгтэй. Саяхан би БНХАУ ороод Эрээнээс Хөх хот нислээ, 260 юань гээд зуун гучхан мянган цаас л байна шүү дээ.

Эрээнээс өнөөдөр Бээжин Нисэхэд 320 юань гээд үндсэндээ 160000 цаасны л үнэтэй байж байна шүү дээ.

Тэгэхээр одоо бид нар аль болохоор юу гэдэг юм энэ иргэдийнхээ энэ олж байгаа орлого, цалин тарианд тааруулж энэ дэд бүтцийнхээ энэ зардал чирэгдлийг хийгээд явах нь зөв байх л гэсэн ийм бодолтой байж байгаа юм. Энэ аялал жуулчлалын талаар ч ер нь тийм шүү дээ. Ер нь сая явж байхад танай Монгол Улсын дэд бүтэц нь ямар байна вэ? Танай онгоцны буудалд өдөртөө хэчнээн онгоц хүлээж авах чадамжтай юм. Онгоцны

чинь зардал ямар байдаг юм гэдэг ийм асуудлууд л ярьж байна шүү дээ. Одоо энэ Морин тойруулгын тухай хуулиар гадагшаа яваад ирэхэд. Тэгэхээр бид нар энэ үнийнхээ асуудал дээр ялангуяа энэ дэд бүтцийн асуудлаа бас тодорхой юу гэдэг юм багасгаж байж энэ гадна дотнын аялал жуулчлалыг авна гэдэг асуудлыг л ярих хэрэгтэй. Тэгэхгүй ийм өндөр зардалтай байхад бол манай Монгол Улсад ирж байгаа аялал жуулчлал их хэмжээгээр ирэх ямар ч бололцоо боломж байхгүй юм байна лээ. Тийм учраас би энийг дэмжиж байгаа юм гэдгээ хэлмээр байна.

Ц.Цэрэнпунцаг: Одоо аль аль нь хоёр сайдаас ч бай, аль алинаас нь хариулт авах вэ дээ Засгийн газар дээрээ уул нь энэ асуудлаа яривал зүгээр юм байгаа юм.

Тэгээд Засгийн газар дээрээсээ нэг шийдэлтэй уул нь ороод ир гэж тохироод хойшлуулсан шүү дээ. Та 2 тэгэхээр би уул нь Бямбацогт сайдтай ярилцаж байсан юм. Одоо энэ Агаарын тээврийн тухай хууль орж ирэхээр тэрэн дээрээ энэ асуудлаа уул нь яриад явчихвал зүгээр юм биш үү гээд нэг ийм байгаа юм.

Ер нь зүгээр Эдийн засгийн байнгын хороо гээд бид хэд чинь энд суугаад нэг ийм эдийн засгийн асуудал гээд л яриад суугаад байдаг. Тэгээд бид нар чинь энэ нэг салбарыг хөгжүүлэхийн тулд тэгээд энэ тэр хөгжүүлэхийн тулд үгүй ээ тэгээд л нэг салбарыг хөгжүүл гээд бусад салбаруудаа бас чирчхэж болохгүй.

Бусад салбарууд маань бас л бүгд л энэ татаас яривал бүгд л бүгд л ярина. холбогдолтой байна. Гарцаа байхгүй аялал жуулчлал гээд тээвэртэй холбоотой байдаг юм гээд яривал бүх л юм тээвэртэй холбогдоод л явчихна. Тэгэхээр холбогдох хоорондоо ингэж уялдаа холбоогүй салбар гэж олдохгүй болохоор ингээд л арай л өргөн ингээд л дэндүү л зах хязгааргүй одоо яг хил хязгаараа давсан

ийм л харьцаа руу л бид нар орчхоод байгаа болохоор их хэцүү байгаа юм л даа.

Жавхлан сайд нэг тайлбар хэлчих.
1 минут.

Б.Жавхлан: Юуны өмнө Засгийн газрын 2 гишүүн Байнгын хороон дээр орж ирээд эсрэг тэсрэг байр суурь илэрхийлээд кабинетын зарчмаар ажиллаж чадахгүй онигоо л болж байна даа. Засгийн газраас өргөн барьсан хувилбараа Бямбацогт сайд өөрөө эсэргүүцэж байгаа юм байна гэж би ойлголоо. Саяын таны яриад байгаа олон улсын нислэгийн тэр НӨАТ-гүй байдгийг та өөрөө тэр НӨАТ-ынхаа татварыг ерөөсөө ойлгохгүй байгаа юм уу даа. Наад олон улсын нислэгийн дотор чинь эцсийн хэрэглэгч хаана үүсэж байгаа нь өөрөө аягүй тодорхойгүй байдаг байхгүй юу. Нэг улсаас нөгөө улс руу өөр авиа компаниар өөр улсад бүртгэлтэй ААН-ийн тээврийн компани оператор компани зөөдөг.

Хаана эцсийн хэрэглэгч үүсэж байгаа нь тодорхойгүй учраас энэ хэрэглэгчийн татвар болох НӨАТ-ыг авдаггүй. Энэ олон улсын конвенцоороо шийддэг ийм асуудал, шал тусдаа асуудал. Төмөр зам чинь анх байгуулагдахдаа НӨАТ-гүй явчихсан. Онцгой албан татвар байхгүй. Ингээд 60 жил яваад ирчихсэн байгаа. Таны ярьж байгаа тэр татаас бол тусдаа.

Ц.Цэрэнпунцаг: Бямбацогт сайд нь 1 минут сайхан тайлбар хэлчих.

Бямбацогт сайдын микрофоныг нээе.

С.Бямбацогт: Бямбацогт сайдын микрофоныг нээедээ. Засгийн газраас надад дотоодын нислэгийг сэргээ, орон нутгийн нислэгийн үнэ тарифыг хямдруул гэсэн бас үүрэг өгсөн юм. Монгол Улсын Их Хурлаас бас төсвийн хууль дагуулаад тогтоол батлаад энэ орон нутгийн нислэгийг сэргээгээд дотоодын нислэгийн

тийзийг хямдруул гэсэн бас хууль баталсан. Энийг л хэрэгжүүлэх гэж байгаа юм. Ингэхийн тулд нэг талдаа бид нар өрсөлдөөнийг дэмжинэ. Нөгөө талдаа бас боломжийг бий болгож өгөх ёстой.

Өнөөдөр төмөр замын дотоод тээвэр НӨАТ-гүй байж байгаа. Гадаад нислэг НӨАТ-гүй байж байгаа. Зорчигч тээвэр дотоодын автобус тээвэр бүгд НӨАТ-гүй байж байгаа. Ганцхан дотоодын нислэг дээр л НӨАТ-тай байгаад байгаа юм л даа. Гэтэл чинь өнөөдөр Улаанбаатараас Дархан ороход хэдээр явдаг билээ. 30000, 10000.

Улаанбаатараас Ховд ороход тийм үү автобусаар явахад 150000 онгоцоор явах юм бол 1500000.

НӨАТ-ыг нь нэг 10 хувь болгочих юм бол 150000 бол хэмнэгдчих гээд байгаа байхгүй юу. Ийм байдлаар бид нар алслагдсан бүс нутагт орон нутгийн иргэдэд нислэгээ сэргээе.

Дээрээс нь энэ Монголд ирсэн жуулчдаа бид яах вэ? Жуулчид аа?

Ц.Цэрэнпунцаг: Ингээд гишүүд ээ саналаа хураая. Тэгээд саналаа хураая Сая би томъёоллыг уншихсан тийм ээ. Энд уншсанаар танилцуулсан. Тийм учраас энэ чинь 5 ш төсөл тав биз дээ.

Ингээд санал хураалт явуулъя. Санал хураалтыг дэмжиж байгаа гишүүд нь гараа өргөчих Ганхуяг гишүүн, Энхтүвшин гишүүн. Дэмжээгүй гишүүд нь 5 гишүүн болчихоод байна. Тэгээд дэмжигдсэнгүй. Энэ санал гомдлыг чинь. Бид нар дэгээ өөрчлөөд явж байгаа юм бид нар. Ингээд Батлут гишүүн би сая утсаар асуугаад Батлут гишүүн, Булгантуяа гишүүн, Чинзориг гишүүн нар кабинетын зарчмаар бид нар шийдвэрээ гаргасан. Сангийн сайдынхаа бид нар дэгээ угаасаа ил хураая гээд түрүүнээс хойш ингээд явж байгаа юм.

Ингээд санал хураалгачихъя тэгэх үү?

Дэг явчихсан. Тэгэхээр дэг зөрчиж байгаа юм байна уу? Ирцэд орсон хэдэн гишүүн байгаа юм. Үгүй биш ээ энэ танхимд сууж байгаа нь хэд байна? 1, 2, 3 биш 5 байна шүү дээ.

Тийм бид 5 сууж байна шүү дээ. Адьшаа гишүүн ажлын хэсэгт байгаа, манай Байнгын хорооны гишүүн биш. Тийм Бямбацогт сайд бол биш, ажлын хэсэг. Тэгэхээр 5 гишүүнд саналаа хураачихъя. Байна уу энэ асуудал дээр байна шүү дээ. Ингээд санал хураалт явуулъя.

Дэмжиж байгаа гишүүд гараа өргөчихье.

Саяын санал 3 гишүүн дэмжээд бусад нь дэмжсэнгүй ээ гэсэн үг.

Ингээд сайд нь ингээд гишүүдийн 30 хувь нь дэмжиж, саяын санал дэмжигдсэнгүй. Ганибал гишүүнд баярлалаа.

Саяын Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоо дээрээс санал хураая.

1.Төслийг хууль санаачлагчид нь буцаах санал гаргасан ажлын хэсэг санал хураалт гишүүдийн хэдэн хувь нь вэ?

60 хувь нь дэмжиж санал дэмжигдлээ.

Амьтны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол:

1.Төслийг хууль санаачлагчид нь буцаах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Гишүүдийн 60 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол:

1.Төслийн 1 дүгээр зүйл буюу 29.1.12 дахь заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Гишүүдийн 60 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйл буюу 29.13 дахь заалтын “отоглох цэгээр” гэсний өмнө “улсын тусгай хамгаалалттай газар нутгаас бусад газарт байрлах” гэж нэмж, заалтын дугаарыг “29.1.12” болгож өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Гишүүдийн 60 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

3.Төслийн 2 дугаар зүйлийн “29.1.13,” гэснийг “29.1.12,” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Гишүүдийн 60 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

4.Төслийн 3 дугаар зүйлийн “29.1.1-29.1.12 дахь заалт” гэснийг “29 дүгээр зүйлийн 29.1.1-29.1.11 дэх заалт” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Гишүүдийн 60 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд нэмэлт,

өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол:

1.Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 1 дэх заалт нэмэх:

1/33 дугаар зүйлийн 4 дэх хэсэг:

“4.Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр байгаль хамгаалал, соёл, аялал жуулчлалыг дэмжихэд чиглэсэн үйл ажиллагаа явуулах шаардлагаар төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, нутгийн захиргааны байгууллага тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглахтай холбоотой харилцаанд энэ хуулийн 27.12-т заасан журам үйлчлэхгүй бөгөөд хүсэлтийг үндэслэн гэрээ байгуулж ашиглуулна.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Гишүүдийн 60 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 2 дахь заалт нэмэх:

2/33 дугаар зүйлийн 5 дахь хэсэг:

“5.Аялал жуулчлалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.10-д заасан аялал жуулчлалын дэд бүтцийг хөгжүүлэх, бий болгох зорилгоор газар ашиглах хүсэлт гаргасан иргэн, хуулийн этгээдэд газар ашиглах эрх олгоход мөн хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.6-д заасан төлөвлөгөөнд тусгагдсан газарт Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 10-т заасныг үндэслэн сонгон шалгаруулалтыг хялбаршуулсан журмаар явуулж болно. Санал гаргасан ажлын хэсэг.

Ганхуяг гишүүн саналаа хэлье.
Ганхуяг гишүүний микрофоныг нээе.

Х.Ганхуяг: Энэ сонгон шалгаруулалтыг хялбаршуулсан журмаар гэдгийг энэ хуульд заасны дагуу явуулж болно оо гэдэг юу оруулах юм. Яагаад гэвэл зөвшөөрлийн хууль дээр хялбаршуулсан журмаар гэдэг юм байхгүй байгаа юм.

Ц.Цэрэнпунцаг: Журмаар гэсний дараа энэ хуульд зааснаар явуулж болно оо гэж орууллаа найруулгыг.

Санал хураалт.

Гишүүдийн 60 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

3.Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 3 дахь заалт нэмэх:

3/36¹ дүгээр зүйлийн 5 дахь хэсэг:

“5.Энэ хуулийн 33 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасан хялбаршуулсан журмаар сонгон шалгаруулалтыг явуулах тохиолдолд энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан тухайн тусгай хамгаалалттай газар нутгийн газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөг үндэслэхгүй байж болно.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Гишүүдийн 60 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

4.Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 4 дэх заалт нэмэх:

4/36² дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2 дахь заалт:

“2/Энэ хуулийн 33 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасан хялбаршуулсан журмаар сонгон шалгаруулалтыг явуулах тохиолдолд зарыг уг ажиллагааг явуулахаар товлосон өдрөөс 10-аас доошгүй хоногийн өмнө цахимаар болон өдөр тутмын хэвлэлээр нийтэд мэдээлнэ.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Гишүүдийн 60 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

5.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 34 дүгээр зүйлийн 34.3 дахь хэсэг, мөн зүйлийн 2 дахь заалт буюу 40 дүгээр зүйлийн 40.1.3 дахь заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Гишүүдийн 60 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

6.Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 36² дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2, 3 дахь заалтын дугаарыг “3, 4” гэж өөрчилсүгэй.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Гишүүдийн 60 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналуудаар санал хураалт явуулж дууслаа.

Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд ажлын хэсгийн ахлагч Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг уншиж танилцуулна.

Эдийн засгийн байнгын хорооны өнөөдрийн хэлэлцэх асуудал дуусаж, хуралдаан үүгээр өндөрлөж байна. Ингээд хуралдаанд идэвхтэй оролцсон гишүүддээ баярлалаа. Ганибал гишүүнд баярлалаа. Жавхлан сайд, Ажлын хэсгийн ахлагч Ганхуяг гишүүнд баярлалаа. Маш сайн ажиллаа. Баярлалаа та бүхэнд.

17:40

Дууны бичлэгээс буулгасан:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ
П.МЯДАГМАА